



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.01.16 №02 (10679)

Үнэ 500 төгрөг

— Дугаар эрхэлсэн дэслэгч Д.БОЛОРМАА

ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА НАРЫН ЦУГЛАРАЛТ БОЛНО

Батлан хамгаалах яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга нарын "Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хангах нь" сэдэвт цугларалтыг 2020 оны 1 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд Батлан хамгаалах яам Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран орон нутагт хоёр дахь удаагаа зохион байгуулж явуулахаар төлөвлөн ажиллаж байна. Өнгөрсөн 2019 оны цугларалтыг "Орон нутгийн хамгаалалт батлан хамгаалах тогтолцооны тулгуур үндэс болох нь" сэдвээр зохион байгуулж, цугларалтын үеэр орон нутгийн хамгаалалтын удирдлага, төлөвлөлтийн үндсэн баримт бичиг болох "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г боловсруулах, хэрэгжилтийг хэрхэн хангах талаар аргачилсан сургалтыг явуулж, нэгдсэн ойлголтод хүрч байсан. Цугларалтаар олгосон мэдлэг, мэдээлэл, Батлан хамгаалахын сайдын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабууд орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг идэвх, чармайлт гарган боловсруулж Батлан хамгаалахын сайдаар батлуулсан нь бидний



зохион байгуулсан цугларалтын үр дүн юм. 2019 онд Батлан хамгаалах яамнаас Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын тогтоол, Батлан хамгаалахын сайдын тушаалаар нилээдгүй журам, зааврыг батлуулаад байгаа юм. Үүнд, Иргэн, цэргийн бэлтгэл үүрэгтнийг орон нутгийн хамгаалалтын болон цэргийн бэлтгэл сургалт, цэргийн дайчилгаатай сургуульд оролцуулах хугацааны цалин хөлсний дундаж хэмжээг тогтоох, түүнийг олгох журам, Дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журам, Дайчилгааны нөөцийг бүрдүүлэх журам, Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчийг дайчилсан тохиолдолд нөхөх олговор төлөх журам, Дайчилгаатай сургууль явуулах журам, Техник хэрэгслийг дайчилгаатай сургуульд татан оролцуулсны хөлсийг төлөх журам,

Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжээс дайчилсан санхүүгийн нөөцийг буцаан төлөх журам, Цэргийн бэлтгэл албаны сургалтын журам зэрэг болно.

Түүнчлэн "Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, тэдгээрийг дайчлах журам"-ын төслийг боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгчөөр батлуулахаар өргөн бариад байна. Энэхүү журмуудын хэрэгжилтийг орон нутагт хангах субъект нь аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб юм. Энэ ч утгаараа энэ удаагийн цугларалтаар 2020 оны үйл ажиллагааныхаа зорилго, зорилтыг тодорхойлж, Цэргийн штабууд ямар ажил, арга хэмжээнд гол анхаарлаа хандуулж ажиллах талаар ярилцахын зэрэгцээ дээр дурдсан эрх зүйн актуудыг орон нутагт хэрхэн хэрэгжүүлэх талаар санал солилцож, туршлагаа хуваалцах юм.

Хурандаа Д.СОДНОМДАРЖАА

ЦЭРГИЙН БҮРТГЭЛ ЭХЭЛНЭ

Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу Цэргийн бүртгэлийг энэ оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 2 дугаар сарын 7-ны өдрүүдэд засаг захиргааны анхан шатны нэгж болсон хороо тус бүр дээр зохион байгуулах юм. Цэргийн бүртгэлийг хууль, журамд нийцүүлэхийн хамт иргэдийг бүрэн хамруулан цаг хугацаанд нь зохион байгуулах асуудлаар нэгдсэн ойлголтод хүрэх зорилго бүхий сургалтыг нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нар болон офицеруудтай явууллаа.

журмыг Батлан хамгаалахын сайдын 2017 оны тушаалаар баталсан бөгөөд уг журмын дагуу бүртгэлийн ажлыг явуулдаг ажээ. Цэргийн бүртгэлийн тогтолцоо нь цэргийн бэлтгэл үүрэгтний тоо, чанарт дүн шинжилгээ хийх үйл ажиллагааны цогц бөгөөд Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэгт "Цэргийн бэлтгэл алба хаах насны иргэн жил бүр цэргийн бүртгэлд бүртгүүлж, цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэгээ хийлгэнэ" хэмээн заасан байдаг юм. Эл бүртгэлд 18-50 насны эрэгтэйчүүд, 60 хүртэлх насны



ЦУГЛАРАЛТЫН ҮЕЭР ШУУРХАЙ ДАДЛАГА ЯВУУЛАВ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагын харьяа нэгтгэл, ангиудын штабын дарга нарын цугларалт хоёр хоногийн хугацаатай зохион байгуулагдлаа. Цугларалтын эхний өдөр штабын дарга нар цэргийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган, удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулах талаар зааварчилгаа өгч, нэгдсэн ойлголтод хүргэх зорилгоор "Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын удирдлагын тогтолцооны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага", "Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулахад Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын дэмжлэг" сэдвүүдээр Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр, Хуурай замын цэргийн командлагын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн

бэлэн байдлын офицер, хошууч Т.Уламбаяр нар лекц уншиж, штабын дарга нартай шуурхай дадлага явуулав. Дараагийн өдөр Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн төлөвлөлтийн шинэчлэлтэй уялдуулан нэгтгэл, ангиудын удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжилтийг ханган, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд командлагын хэлтэс, тасгийн дарга нар болон төрөл мэргэжлийн цэргийн дарга нартай уулзалт зохион байгуулж, тэдний санал, сэтгэгдлийг сонссон юм. Мөн "Зэвсэгт хүчний 2019-2020 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулж явуулахад штабын дарга нарын үүрэг, оролцоо", "Хуурай замын цэргийн 2020 оны хүний нөөцийн бодлого, тулгамдаж буй зарим асуудал" зэрэг сэдвээр цугларалтад оролцсон бүрэлдэхүүнтэй

харилцан яриа өрнүүлсэн нь энэ удаагийн цугларалтын нэгэн онцлог байлаа. Дараа нь цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг мөрдүүлж, хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт, шалгалтыг тасралтгүй зохион байгуулж, цэргийн алба, сахилга, дэг журмыг бэхжүүлэх зорилтын хүрээнд "2019 оны цэргийн сахилгын дүн", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга, дэг журмыг бэхжүүлэх зөвлөл"-ийн 2020 онд дэвшүүлсэн зорилго, түүнийг хэрэгжүүлэх арга зам" сэдвүүдээр бригадын генерал Л.Онцгойбаяр, Хуурай замын цэргийн командлагын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа О.Эрдэнэбаатар нар илтгэл тавьж, төгсгөлд нь Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар цаг үеийн асуудлаар бие бүрэлдэхүүнд үүрэг, чиглэл өгсөн юм.

Цэргийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх онол, арга зүйг эзэмшүүлэх, цэргийн сургалт бэлтгэлийг дээшлүүлэх талаар нэгдсэн ойлголтод хүрэх, улс орны бүтээн байгуулалтын ажилд оролцох бэлтгэл ажлыг хангах зэрэг асуудлыг хэлэлцэж, штабын дарга нарын мэргэжил, арга зүй, бие бялдрын түвшинг тодорхойлон нэгтгэл, ангиудын үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шуурхай дадлагыг явуулсан зэрэг нь энэ удаагийн цугларалтын гол онцлог байсан юм.

Ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ

Сургалтыг Нийслэлийн Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Болдбаатар удирдсан бөгөөд энэхүү цэргийн бүртгэлтэй холбоотой сэдвүүдээр тус штабын хурандаа Т.Мөнхбаяр, дэд хурандаа С.Баярмагнай, хошууч Б.Чимэд нар хичээл зааж нэгдсэн ойлголтод хүрлээ. Сургалтын явцад цэргийн бүртгэлийг зохион байгуулж явуулах бэлтгэл ажлыг хэрхэн хангасан талаар дүүрэг бүрийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нар мэдээлэл, танилцуулга хийсэн нь онцлог байсан ба төгсгөлд нь Засаг даргын Тамгын газрын дарга Р.Батрагчаа, Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Болдбаатар нар үүрэг, чиглэл өгснөөр энэ удаагийн сургалт өндөрлөв.

Энд тодруулахад, Цэргийн бүртгэл явуулах

бэлтгэл дээд болон ахлах офицерууд, 55 хүртэлх насны бэлтгэл дунд офицер, ахлагч нар хамрагддаг болохыг манай уншигчид мэдэх биз ээ. Энэ жилийн хувьд Цэргийн бүртгэл нь Монгол Улсын хүн ам, орон сууцны ээлжит тооллогын дараа явагдах шийдвэр гарснаараа онцлог юм.

Сургалтын төгсгөлд хурандаа Ж.Болдбаатар нийт офицеруудад хандаж цэргийн бүртгэл нь нийт 173 хороонд нэгэн зэрэг явагдах бөгөөд аливаа ажлын гол зүүлэлт нь цаг хугацааны шалгуур байдаг тул цаг хугацаанд нь хууль, журмын хүрээнд нарийвчилсан судалгаанд тулгуурлан мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах нь чухал болохыг онцоллоо.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

УТААГҮЙ НИЙСЛЭЛИЙН ТӨЛӨӨ

БХЯ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нийслэлд түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор иргэдийг сайжруулсан шахмал түлшээр хангах "Таван толгой түлш" ХХК-ийг байгуулан төвийн зургаан дүүргийн 381 цэгт түлш түгээж байна.

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан нийслэлийн Онцгой комиссын шийдвэрээр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт илжин төвийн зургаан дүүрэгт



шуурхай штаб байгуулан, хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулан сайжруулсан шахмал түлшний хэрэглээ, түгээлтэд 24 цагийн турш хяналт тавьж байгаа юм.

Энэхүү шийдвэрийн хүрээнд нийслэлийн иргэдийн эрүүл агаар, цэвэр орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангах, сайжруулсан шахмал түлшний иргэдэд

хүртээмжтэй хүргэх зорилгоор хотын төвийн зургаан дүүргийн автомашин зорчих боломжгүй 25 өндөрлөг цэгт байрлах айл өрхүүдэд 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Зэвсэгт хүчний ангиудаас тулаха чадвартай "ЗИЛ-131" маркийн 28 автомашинаар өдөр бүр түгээлт хийж байгаа юм.

Хурандаа Г.НЭРГҮЙ

ТЭД ШИНЖИЛДЭГ, ИЛРҮҮЛДЭГ, СУДАЛДАГ, ОНОШИЛДОГ

Уншигч та эсвэл таны эргэн тойрны хэн нэгэн Цэргийн төв эмнэлэгт мухар олгой авахуулах мэс засалд орлоо гэж бодъё. Мэдээж эмч нар өвчтөнд мэс заслыг амжилттай хийж, өвчнөөс нь салгана. Ингээд л бүх зүйл дуусчихаж байгаа юм биш ээ. Үүний дараагаар Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлгийн хамт олны шат дараалсан жинхэнэ ажил эхэлнэ. Өөрөөр хэлбэл, мэс заслын дараа тухайн эд,



эрхтэнд шинжилгээ, судалгаа хийж, хавдар илэрсэн тохиолдолд эрт үед нь оношлох боломжийг эмчлүүлэгчдэд олгодог маш хариуцлагатай ажил явагддаг гэсэн үг. Энэ бол тус байгууллагын ажил, үйлчилгээний зөвхөн нэг чиглэл нь.

Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлгийн түүхтэй холбоотой нэгэн баримтыг сөхвөөс, Засгийн газрын шийдвэрээр онц эрх бүхий тусгай комисс томилогдож, Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин Д.Сүхбаатарын цогцост 1923 оны 2 дугаар сарын 28-ны өдөр задлан шинжилгээг хийсэн тухай "МОНТА" сонинд хэвлэгдэж байжээ. Чухам энэ өдрөөс тус байгууллагын үндэс суурь нь манай улсад эхлэн тавигдсан гэж үздэг байна. Эмгэг судлал, шүүх эмнэлэг нь анх одоогийн Цэргийн төв эмнэлгийн хүлээн авах тасгийн хажууд Шүүх эмнэлэг, эмгэг анатомийн кабинет нэртэй үүдээ нээж байжээ.

(Үргэлжлэл нь IV нүүрт)

ТОДРУУЛГА

Д.Цэрэн: НИЙГМИЙН АСУУДЛАА ШИЙДҮҮЛЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ ДИЙЛЭНХ ХУВИЙГ ЭЗЭЛДЭГ

Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Д.ЦЭРЭН

Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2019 онд хэдэн өргөдөл, гомдол ирсэн бэ? Тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээлэл өгөхгүй юу?

-2019 онд Батлан хамгаалах яамны тавигдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаандаа иргэдээс ирүүлсэн ажил хэрэгч санал, хүсэлтийг судлан тусгах, Засгийн газраас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх, өргөдлийг хүлээн авах, зохих шийдвэр гаргаж, хариу өгөх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд 2019 онд БХЯ болон харьяа байгууллага, албан тушаалтанд нийт 18796 иргэн өргөдөл, санал, хүсэлт, ирүүлснээс 17768 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж 654 өргөдлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэсэн ба иргэнд эргүүлэн хариу өгсөн нь 98 хувийн үзүүлэлттэй байна. Өнөөдрийн байдлаар 61 өргөдлийн шийдвэрлэх хугацаа нь болоогүй, шалган тодруулах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал хүсэлтийн 75,4 хувь нь бичгээр, 0,2 хувь нь цахимаар, 0,05 хувь нь утсаар, 24,4 хувь нь биечлэн уулзаж өгсөн.

Дээр дурдсан өргөдлийн хэдэн хувь нь Батлан хамгаалах яаманд хаяглагдан ирсэн бэ?

-Батлан хамгаалах салбарын удирдах байгууллага учир Батлан хамгаалах яаманд хаяглагдаж ирсэн өргөдөл багагүй хувийг эзэлдэг. Тухайлбал, 2019 онд БХЯ-ны албан тушаалтанд иргэдээс нийт 980 өргөдөл, гомдол ирснээс 969 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, 10 өргөдлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэж, иргэнд хариу өгсөн нь 98,8 хувийн үзүүлэлт юм. Өнөөдрийн байдлаар 11 өргөдлийг шалган тодруулж шийдвэрлэж байна. Ер нь иргэдээс ирсэн өргөдлийн 32,4 хувийг Батлан хамгаалахын сайдад, 1,7 хувийг Батлан хамгаалахын дэд сайдад, 17,9 хувийг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад, 34,1 хувийг Төрийн захиргааны удирдлагын газарт, 2,2 хувийг бусад газар, хэлтсийн дарга нар, 11,7 хувийг Орон сууцны комисст тус тус хаяглан ирүүлсэн байна.

Хамтран ажилладаг төрийн болон төрийн бус бусад байгууллагаас хэр их өргөдөл, гомдол ирсэн болоод хэрхэн шийдвэрлэсэн талаар ...

-2019 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Нутгийн болон захиргааны удирдлагын байгууллага, Батлан хамгаалах



яамны харьяа байгууллагаас шилжин ирсэн өргөдлийг судлан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохио шийдвэр гаргаж, хариу өгч ажилласан. Нийт шилжин ирсэн өргөдлийн 8,5 хувь нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас, 14 хувь нь Монгол Улсын Их Хурлаас, 26,5 хувь нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас, 4,9 хувь нь нутгийн болон захиргааны удирдлагын байгууллагаас, 46,1 хувь нь БХЯ-ны харьяа байгууллагаас тус тус ирсэн байна.

Өргөдлүүдийг агуулгаар нь ангилбал ямар асуудлын талаар дурдсан байдаг юм бэ?

-Батлан хамгаалах салбарын хэмжээнд хаяглагдан ирсэн өргөдлийн дийлэнх хувь нь амьдрах орон сууц болоод гэр, мөнгөн тусламж, дэмжлэг хүсдэг. 2019 онд иргэдээс ирсэн өргөдлийн 29,8 хувь нийгмийн асуудлаа шийдүүлэхийг хүссэн, 15,5 хувь нь ажлын байр болон шилжин ажиллахыг хүссэн, 14,8 хувь нь гадаад, дотоодын сургууль, дамжаанд суралцахыг хүссэн, 7,4 хувь нь цэргийн тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авахыг хүссэн, 16 хувь нь ахмад дайчны гэр бүл, үр хүүхдээс үнэмлэх, тэтгэмж, орон сууц хүссэн, 8,1 хувь нь хүүхдээ цэцэрлэгт элсүүлэх хүсэлт, 8,4 хувь нь бусад асуудлаар тус тус хүсэлтээ ирүүлсэн байна.

Ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр ямар ажил зохион байгуулсан бэ?

-Батлан хамгаалах яамны нээлттэй байдлыг хангах, иргэдэд санал, хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх бололцоог олгох зорилгоор нийт зургаан сугаар иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байна. Үүнд Иргэдийг хүлээн авах байранд биечлэн уулзах, утсаар буюу 458929 дугаарт, Засгийн газрын санал, хүсэлт хүлээн авах "11-11" төвөөс хуваарилагдаж ирсэн болон tseren@mod.gov.mn хаягаар зэрэг олон хэлбэрээр иргэдээс санал авч байна. 2019 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын 92,3 хувь нь бичгээр, гурван хувь нь цахимаар, 4,7 хувь нь биечлэн уулзаж өгсөн.

Сүүлийн үед иргэдэд үзүүлэх үйлчилгээг илүү хурдан

шуурхай болгох олон ажил улс орны хэмжээнд өрнөж байна. Энэ чиглэлээр БХЯ-наас ямар бодлого баримталж байна вэ?

- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан "Тогтвортой, хариуцлагатай, эрх зүйт төрийг төлөвшүүлэх чиглэлээр төрийн захиргааны албан тушаалтан иргэдийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх хугацааг хоёр дахин бууруулж, хөнгөн шуурхай болгоно" гэж заасны дагуу богино хугацаанд шийдэх боломжтой өргөдлийг хуулийн хугацааг хүлээхгүйгээр шийдвэрлэж, хариу өгч ажиллалаа. Энэ дагуу иргэдээс ирсэн өргөдлийг шийдсэн хугацаагаар нь харуулбал 1-3 хоногт 150 буюу 15,3 хувь, 4-7 хоногт 298 буюу 30,4 хувь, 7-14 хоногт 173 буюу 17,7 хувь, 14-30 хоногт 334 буюу 34,1 хувийг тус тус шийдэж хариу өгсөн бөгөөд хуульд заасан хугацаа сунгаж шийдсэн 25 өргөдөл байгаа нь нийт өргөдлийн 2,5 хувийг эзэлж байгаа юм. Мөн шууд шийдвэрлэх боломжгүй, удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудлууд байдаг. Тухайлбал орон сууц, мөнгөн тусламж, сургалт зэрэг юм. Эдгээрийг өргөдлийн тусгай бүртгэлд бүртгэн дараалалд оруулж, шийдвэрлэлтэд нь хяналт тавьж ажиллахын зэрэгцээ яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй, албан ёсоор нийтэд зарласан асуудлаар гаргаагүй өргөдөл, гомдлыг харьяалах газарт нь гурван хоногийн дотор шилжүүлэн энэ тухай иргэнд хариу мэдэгдэж ажиллалаа. Иргэдэд өргөдлийн хариу ихэвчлэн албан бичгээр өгдөг боловч зарим тохиолдолд биечлэн эсвэл харилцах утсаар гэсэн аль болох түргэн шуурхай хүргэх тохиромжтой хэлбэрийг сонгон ажилладаг.

Монгол Улсын Засгийн газрын "11-11" төвд Батлан хамгаалах салбартай холбоотой ямар асуудлууд зонхилж ирдэг вэ? Мөн тэдгээрийн хэрхэн шийдвэрлэдэг талаар ...

-Засгийн газрын иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах "11-11" төвөөс Батлан хамгаалах яаманд хуваарилагдан ирж буй санал, хүсэлт, гомдлын дийлэнх хувь нь эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээ, цэрэг татлага зэргээр санал бодлоо илэрхийлсэн байна. Эдгээр иргэдээс ирүүлсэн санал, гомдлыг цаг тухай бүрт нь хүлээн авч тодотгон, шаардагдах арга хэмжээ авч шийдвэрлэн, хариу илгээж ажилласан. 2019 онд "11-11" төвөөс 29 санал ирсэн ба 13 нь гомдол, 16 нь санал хүсэлт байлаа.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

Редакцын шууданд

Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Аймгийн "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г аймгийн Засаг даргад хүлээлгэн өгөх ёслолын арга хэмжээг энэ сарын 8-ны өдөр зохион байгууллаа. Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Г.Нэмэхбаяр Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, түүний хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулагдсан "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-ний талаар мэдээлэл өгч, төлөвлөгөөг орон нутгийн удирдлагуудад гардуулсан юм. Арга хэмжээнд аймгийн Засаг дарга Д.Батсайхан, ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Унэнхүү, ЗДТГ-ын дарга Л.Лхамсүрэн, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлагууд оролцов.

Хошууч Г.БАВУУДОРЖ

311 дүгээр анги

Ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс "Эрүүл агаар эм" сэдэвт явган аяллыг эмэгтэйчүүдийн дунд зохион байгууллаа. Явган аяллаар уулын оргил булаацалдах, сумо барилдаан, буухиа тэмцээнүүд зохиогдсон бөгөөд сумо барилдаанд тогооч Т.Дудиаре, буухиа тэмцээнд гал тогооны хамт олон тэргүүлээ. Мөн аяллын явцад ойролцоох хог хаягдлыг түгж, байгаль орчинд ээлтэй ажлыг өрнүүлэв.

Ц.САЙНЗАЯА

326 дугаар анги

Засгийн газраас хэрэгжүүлж буй нийслэлийг утаагүйжүүлэх ажилд тус ангийн бие бүрэлдэхүүн оролцож байна. Тухайлбал, "Тавантолгой түлш" ХХК-ийн үйлдвэрлэж буй сайжруулсан түлшийг савлах ажилд зургаан нэгж техниктэйгээр 48 цэргийн алба

хаагч томилогдон, өдөрт дунджаар 60 тонн буюу 2400 шуудай нүүрсийг бэлтгэж, Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэдэд хүргэн хүлээсэн үүргээ амжилттай гүйцэтгэж байгаа юм.

Мөн энэ сард салбар, нэгжийг сурталчлах аяныг өрнүүлж байна. Энэ хүрээнд олон ажил, арга хэмжээ зохион байгуулснаас "Нэг алба-нэг олгой хаймар" аяныг өрнүүлсэн ба "Зил-131" автомашины 12 ширхэг дугуйны дотуур олгой цугларсан юм.

Ахмад Э.ГАНБАЯР


350 дугаар анги

2019-2020 оны сургуулийн жилд тус анги нь амжилт бүтээлээр дүүрэн байж Зэвсэгт хүчний "Цэрэгжилтийн спорт"-ын уралдааны "Аварга анги", ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын 2019 оны "Тэргүүний анги"-аар шалгарч цом, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнууллаа. Мөн Зангилааны дарга, ахмад Ж.Энх-Орчлон Зэвсэгт хүчний "Тэргүүний энхийг сахиулагч офицер" болж анги хамт олноо баярлуулсан юм. Өнгөрөгч 2019 ондоо мөн урлаг, спорт, ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа манлайлж хошуучилсан тэргүүний сайчуудаа тодрууллаа. "Хөдөлмөрийн аварга офицер" -оор ахмад Х.Ууганбаяр, "Хөдөлмөрийн аварга ахлагч"-аар ахлах ахлагч Г.Түвшинжаргал, "Тэргүүний амилтан"-аар нярав Б.Бямбацэцэг, "Тэргүүний хамт олон"-оор 2МБР-ын бие бүрэлдэхүүн, "Шилдэг энхийг сахиулагч"-аар ахмад Ж.Энх-Орчлон, "Шилдэг эрэгтэй тамирчин"-аар дэд ахлагч Ө.Отгонбаяр, "Шилдэг эмэгтэй тамирчин"-аар дэд ахлагч С.Нандин-Эрдэнэ нар тодорлоо.

М.БОЛОРТУЯА

СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА

Батлан хамгаалах яамнаас Төрийн ёслолын хүндэт харуул (Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим)-ын, торгон цэрэг (морьт)-ийн дүрэмт хувцас, хэрэгслэл, цэргийн ёслолын дүрэмт хувцасны загварыг шинэчлэх төслийн хүрээнд сонгон шалгаруулах уралдааныг зарлаж байна.



Тавигдах шаардлага: Хувцас, хэрэгслэлийн загварын шинэчлэлийг түүхэн уламжлал, олон улсын жишиг, орчин үеийн загварын хандлага, шийдлийг шинжлэх ухааны судалгаанд тулгуурлан боловсруулж, уралдаанд өрсөлдөх материалаа илгээнэ үү.

Хугацаа: Материалыг 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 18.00 цаг хүртэл Батлан хамгаалах яамны 221 тоотод хүлээн авна.

Шалгарсан бүтээл шагналтай.

Холбоо барих утас: 263473, 263229, 263263



Хилийн чанадаас мэдээлж байна

АРВАН ХОЁРДУГААР САРЫН ТЭРГҮҮНҮҮДЭЭР...



БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний IX ээлжийн мотобуудлагын

батальоны бие бүрэлдэхүүн шинэ оны босгон дээр 12 дугаар сарын ажлаа тайлагнан амжилт, үр бүтээлтэй ажилласан цэргийн алба хаагчдаа тодрууллаа. Тухайн сард "Тэргүүний штабын офицер"-оор ахмад С.Ууганбаяр, "Шинийг санаачлагч, бүтээлч цэргийн алба хаагч"-аар дэслэгч Х.Хаш-Эрдэнэ, "Тэргүүний салбарын офицер"-оор дэслэгч Б.Төгөлдөр, "Тэргүүний ахлагч"-аар сургагч ахлагч Б.Эрдэнэчулуун, ахлагч Б.Бат-Эрдэнэ, ахлагч Б.Дөлгөөн, "Тэргүүний эмэгтэй цэргийн алба хаагч"-аар ахлагч Ц.Оюунжаргал, "Тэргүүний салаа"-гаар дэслэгч Х.Айхтурбан захирагчтай инженер барилгын салаа тус тус шалгарав.

Тэргүүний цэргийн алба хаагчдаа өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсны зэрэгцээ анги, салбар, ар гэрт нь батальоны захирагчийн "Талархлын захидал"-ыг илгээв.

УРЛАГИЙН АВЬЯАСТНУУДАА ТОДРУУЛЛАА

Бие бүрэлдэхүүний чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, цэргийн алба хаагчдын авьяас чадварыг нээн илрүүлэх, цаашлаад мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэж байгаа бусад орны цэргийн алба хаагчдад үндэсний урлаг, соёлоо сурталчлан таниулах үүднээс "Тэргүүний ардын авьяастан хамт олон" шалгаруулах урлагийн үзлэгийг шинэ оны өмнөхөн зохион байгуулав. Тус уралдаанд хошууч Г.Бат-Амар, хошууч М.Энх-Амар, хошууч Б.Төмөрхуяг захирагчтай рот тус тус эхний байруудад шалгарсан юм. Түүнчлэн "Шилдэг бүжгийн хамтлаг"-аар "Улаан шигтгээ" хамтлаг, "Шилдэг гоцлол дуучин"-аар дэд ахлагч А.Бадамсамбуу, "Шилдэг гоцлол бүжигчин"-ээр ахлагч Б.Мэндбаяр, "Шилдэг гоцлол хөгжимчин"-өөр ахлагч Б.Хасчулуун, "Шилдэг морин хуурч"-аар ахлагч Б.Ананд, "Шилдэг уран уншигч"-аар ахмад Ч.Сэр-Од, "Шилдэг язгуур урлагийн үзүүлбэр"-ийн эзнээр дэслэгч Э.Мэндбаяр, "Шилдэг гоц үзүүлбэр"-ийн эзнээр дэд ахлагч Б.Бат-Од, "Шилдэг хөтөлгөч"-өөр дэд ахлагч Г.Өлзийтуул нар шалгарав.



Ийнхүү "Тэргүүний ардын авьяастан хамт олон" шалгаруулах урлагийн үзлэгийн шилдгийн шилдэг үзүүлбэрүүдээс бүрдсэн хоёр цагийн багтаамжтай тоглолтыг "Арвай", "Жамжан", "Эко", "Хөтөл" баазуудад үүрэг гүйцэтгэж буй цэргийн алба хаагчдаа сонирхуулав.

Түүнчлэн 12 дугаар сарын 31-ний өдөр батальоны шинэ жилийн баярын нэгдсэн арга хэмжээг ч дээрх тоглолтоор чимж, баярт уригдсан НҮБ-ын болон мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэж буй бусад улсын цэргийн багийн удирдлагуудад үндэсний урлаг, соёлоо сурталчилсан юм. Энэ нь "Тэргүүний ардын авьяастан хамт олон" шалгаруулах урлагийн үзлэгийн гол зорилго, үр дүн байлаа.

Ахмад Д.МЭНДБАЯР

АВТОМАШИНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ ӨӨРИЙН БИЕЭР ОЧИЖ ХИЙЛГЭЭРЭЙ!

Автомашин хуурамч бичиг баримт үйлдэн шилжүүлэх хэрэг сүүлийн үед олширч, иргэд автомашины өмчлөлтэй холбоотой асуудлаар цагдаагийн байгууллагад дуудагдах тохиолдол ихээр гарах болсон байна.

Автомашин худалдах, худалдан авахдаа нотариатаар итгэмжлэл хийлгэж, эсвэл худалдах, худалдан авах гэрээ хийснээр нэр шилжсэн гэж үздэг нь том эрсдэлийг дагуулж байдаг. Автомашин худалдан авч байгаа иргэд өөрсдийн биеэр очиж шилжүүлэх хийлгээгүйн улмаас татвар төлөөгүй, оношилгоонд ороогүй, торгууль төлөгдөөгүй автомашин худалдан авах тохиолдол их гарах болсон.

Шилжилт хөдөлгөөн хийгдээгүйн улмаас цааш нь худалдах, Банк бус санхүүгийн байгууллагад барьцаанд тавих зэрэг хууль бус ашиг хонжоо хайсан гэмт хэрэг гарах эрсдэлтэй юм. Иймд автомашин худалдан авахдаа өөрийн биеэр очиж, шилжилт хөдөлгөөнөө хийлгээрэй.

Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны Мэдээлэл, судалгааны мэргэжилтэн, ахмад Д.ДЭЛГЭРМАА

БИДНИЙ ХҮСЭЛ ЗОРИЛГО, ОЧИХ ЦЭГ НЭГ, ТЭР БОЛ ЭХ ОРОН

Сүүлийн хагас жилийн хугацаанд нийгэмд чиглэсэн, иргэд, залуучууд, өсвөр үеийнхэнд эх оронч үзлийг арга хэмжээ бүртээ нэвт шингээсэн асар олон ажлууд хийгдэх болсон. Энэ бүгдийн ард "Монгол цэргийн нэгдсэн холбоо" хэмээх шинэхэн байгууллага орших аж. Байгуулагдсан цагаасаа хойш долоохон сарын хугацаанд 50 гаруй, сард дунджаар 6-10 томоохон ажил, арга хэмжээг зохион байгуулж, нийт 80 гаруй мянган хүнийг хамруулан ийм идэвхтэй үйл ажиллагаа явуулагч байгууллага урьд өмнө нь Монголын нийгэмд өдрийн од шиг ховор байсан. Тэдний хэрэгжүүлсэн арга хэмжээний 18 хувь нь Монгол Улсын иргэдэд эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэх үйлсэд, 10 хувь нь улс орны аюулгүй байдлыг хангах тогтолцоо, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх, цэрэг, цагдаагийн алба хаагчид, хөдөлмөр, соёл, урлаг, шинжлэх ухааны зүтгэлтэн, иргэдийг алдаршуулах, 20 гаруй хувь нь Монголын ард түмний хөдөлмөрч, дайчин, баатарлаг уламжлалыг өсвөр, залуу үеийнхэнд өвлүүлэх чиглэлд, 20 хувь нь цэрэг, цагдаагийн алба хаагчид, ахмадуудын эрх зүй, нийгмийн хамгааллын баталгааг бүрдүүлэх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл хэрэгт тус тус чиглэсэн байна. Ийм ч учраас Монгол цэргийн нэгдсэн холбоо нь Монголын нийгэмд зохих хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн төрийн бус байгууллага хэдийнээ болоод байна гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Хийсэн ажилтай, хийх ажил нь ч улам ундарч буй Монгол цэргийн нэгдсэн холбооны цаашдын үйл ажиллагааны хэтийн төлөвийн талаар тус холбооны ажлын албаны дарга, бэлтгэл бригадын генерал Б.Ганбаатартай ярилцсанаа хүргэж байна.



Монгол цэргийн нэгдсэн холбоо нь анх ямар зорилгын дор хэрхэн нэгдэн байгуулагдаж байсан талаар яриагаа эхлэхгүй юу?

"Эх оронч үзэл, үндэсний бахархлыг хөгжүүлэн, ард түмнээ соён гэгээрүүлж, Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын оюуны дархлаа, үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх үйлсэд төр, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах" эрхэм зорилготойгоор төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмадууд, иргэдийн санаачилга, төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр "Монгол цэргийн нэгдсэн холбоо" төрийн бус байгууллага 2019 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр анхдугаар их хурлаа хийж, үйл ажиллагааны үндсэн чиглэлээ баталснаар анх байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Холбооны баримталж ажиллах зарчим болоод үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдээс сонирхуулахгүй юу?

"Монгол цэргийн нэгдсэн холбоо нь өөрийн дүрэмдээ үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлсон байгаа. Тухайлбал, Монгол Улсын иргэдэд эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэхэд төр, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангах тогтолцоо, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэхэд төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, цэрэг, цагдаагийн алба хаагчид, ахмадуудын эрх зүй, нийгмийн хамгааллын баталгааг бүрдүүлэх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалахад төр, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах, улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, энхийн бүтээн байгуулалтад гавьяа байгуулсан төр, цэрэг, цагдаагийн алба хаагчид, соёл, урлаг, шинжлэх ухааны зүтгэлтэн, иргэдийг алдаршуулах, гадаадын улс орон, олон улсын байгууллага болон иргэний нийгмийн ижил төстэй зорилго бүхий байгууллага, иргэдтэй хамтран ажиллах гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол цэргийн нэгдсэн холбоо байгуулагдсан цагаасаа хойш нийгэм рүү нэгдсэн

олон ажлыг хийж хэрэгжүүлээд байгаа. Энэ талаар ...

"Ажлын алба байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн нь 2019 оны 5 дугаар сарын сүүлч. Ингээд бодохоор он дуустал долоохон сарын дотор үйл ажиллагааныхаа чиглэлүүдийн хүрээнд олон чухал агаад томоохон, өргөн далайцтай арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Тэдгээрийн заримаас нь дурдвал: "Эх оронч монголчууд" шинжлэх ухаан, танин мэдэхүйн лекц, урлагийн тоглолтыг МҮЭ-ийн СТО-д зохион байгуулж нийт 600 гаруй залуучуудыг хамруулсан. Монгол Улсын тэргүүлэх их, дээд сургуулиудын багш, судлаач, оюутнуудтай эх оронч үзэл, хүмүүжлийн томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Тухайлбал, ХААИС-ийн 600 гаруй оюутнуудад "Монгол бахархал, эх оронч үзэл, залуусын ёс суртахууны асуудал" сэдвээр лекц уншиж, урлагийн хэсэгчилсэн тоглолтоор үйлчилсэн, "Даяаршил ба эх оронч үзэл" сэдэвт чуулга уулзалтыг МУБИС-ийн 1300 гаруй багш, оюутнуудтай зохион байгуулсан зэргийг нэрлэж болох юм. Цаашид ШУТИС, МУИС-тай энэхүү арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж байна. Мөн Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага тус бүрээс сургалтын баг гарган олон улсын "Найрамдал" зуслан, ҮБХИС-ийн "Шонхор" зусланг түшиглэн сурагчдын 2019 оны зуны амралтаар 1000 хүүхдийг хамруулан "Эх оронч үзэл-Үндэсний бахархал" сэдэвт танин мэдэхүй, амьдрах ухааны сургалтыг явуулсан.

Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 1800 гаруй сурагчдад эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэх зорилгоор Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Нийслэлийн боловсролын газар, Монгол цэргийн музей, Улсын хилийн музейтэй хамтран эх орны түүх, ахмад үеийн дайчин замналыг харуулсан үзэмрүүдийг үнэ төлбөргүй үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд цаашид эл арга хэмжээг тогтмолжуулан улсын чанартай томоохон музейнүүдтэй хамтран ажиллахаар төлөвлөж байна. Түүнчлэн Монгол Улсын төр, нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтэн мэргэдийн бичсэн эх оронч үзэл, хүмүүжлийн тухай лекцийн

эмхэтгэлийн нэгдүгээр цувралыг хэвлүүлэн салбар холбоод, дэмжигч төрийн болон төрийн бус байгууллагуудад гарын авлага болгон тараагаад байна. Энэ мэт олон ажлуудыг хийгээд байгаа бөгөөд эдгээр нь бидний зохион байгуулсан ажлуудын зөвхөн нэгээхэн хэсэг нь юм.

Олон нийтийн сүлжээгээр дамжуулан ажиллуулж байгаа "Эгэл хүмүүсийн эгэлгүй гавьяа" булан та бүгдийн санаачилсан чухал ажлуудын нэг. Энэ нь хэр хүрээг хамарч байгаа бол ...

"Бид төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчид, тэдгээр байгууллагаас бэлтгэл болон чөлөөнд гарсан ахмад дайчдын байгуулсан, тэр болгон нийгэмд танигдаагүй өнгөрсөн алдар сууг нь сурталчлах, олон нийтэд таниулах зорилгоор энэ буланг ажиллуулж байгаа юм. Энэ булангаар заавал цэргийн том дарга, жанжин биш, жирийн алба хаагчдын үйл хэргийг олны хүртээл болгохыг зорьж байгаа бөгөөд одоогоор төр, нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн, дэслэгч генерал Ч.Пүрэвдорж, сонс эргэлтийн улсын дээд амжилтын эзэн, бэлтгэл офицер Гүрбазарын Чүлтэм, Онцгой байдлын байгууллагын аврагч, ахмад Х.Мөнхбат, аврагч, ахлах ахлагч Т.Ганзориг, цагдаагийн хурандаа Д.Ренцэнрээбуу, шүхэрчин эмэгтэй ахлах ахлагч Г.Хандсүрэн, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн дэд хурандаа Ц.Идэрбат, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ахмад настан Н.Цэрэндолгор нарыг сурталчлаад байна. Бидний бэлтгэн түгээж байгаа мэдээлэл бүр олон нийтийн сүлжээгээр дунджаар 100,000-400,000 хандалт авч байгаа нь тус арга хэмжээ хэчнээн чухал болохыг харуулж байгаа юм.

Цэрэг, цагдаагийн алба хаагчдын нийгмийн хамгааллын баталгааг хангахад чиглэсэн нэлээд олон чухал ажлуудыг амжуулсан гэсэн. Энэ талаар ...

"Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын нийгмийн хамгааллын баталгааг бүрдүүлэх нь бидний үйл ажиллагааны гол чиглэлүүдийн нэг юм. Энэ хүрээнд Орхон аймгийн Засаг дарга, ЗДТГ, дэмжигч бусад байгууллагуудтай хамтран Эрдэнэт хотод "1000 мөрдэстний чуулган"-ыг зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаанд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдах бүрэлдэхүүний төлөөлөл оролцон, тэргүүний 100 гаруй алба хаагчид салбарын шагналуудаар шагнаан урамшуулж, чуулганы төлөөлөгч 1000 гаруй хүн, Зэвсэгт хүчний хоёр ангийн 400 гаруй дайчдад ЦДБЭЧ-ын тоглолт, Монгол цэргийн музейн үзмэрийн сангаас үзүүлж, лекц уншиж, хамгийн гол нь тус аймгийн ЗДТГ-аас жишиг гудамж байгуулан 15 гэр бүлд хувийн хашаа, байшин барьж, газар эзэмших гэрчилгээний хамт олгосон нь тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд томоохон дэмжлэг болсон гэж үзэж байна. Мөн "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэй алба хаагчдын анхдугаар чуулга уулзалт"-ыг зохион байгуулсан. Чуулга уулзалтад Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллагуудаас 100, Зэвсэгт хүчний ангуудаас 365, Хил хамгаалах байгууллагаас 150, Онцгой байдлын байгууллагаас 65, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 200, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 300, Тагнуул, төрийн тусгай хамгаалалтын газраас 50, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 50, Дотоод хэргийн их сургуулиас 20, нийт 1300 эмэгтэй алба хаагч оролцсон бөгөөд чуулга уулзалтын үеэр

эмэгтэй алба хаагчдын нийгмийн болон хууль, эрх зүйн баталгааг хангах чиглэлээр гаргасан санал хүсэлтүүдийг шийдвэрлүүлэх зорилгоор холбооны дэргэд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын төлөөлөл бүхий Эмэгтэйчүүдийн клубийг нээн ажиллуулж байна. Эдгээр нь цэрэг, цагдаагийн алба хаагч руу чиглэсэн ажлуудын зөвхөн нэгээхэн хэсэг нь юм.

Тэтгэвэрт гарсан ахмадуудаас орхигдуулаагүй байх ...

"Тэтгэлгүй яах вэ. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудаас бэлтгэл болон чөлөөнд гарсан иргэдийг давтан сургах, албаны хугацаа дуусч бэлтгэлээр халагдах алба хаагчдыг угтан сургаж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ажиллах нөхцөл, боломжийг нь бүрдүүлэх зорилгоор богино хугацааны зорилтот сургалтын хөтөлбөрийг боловсруулан Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх Удирдлагын академитай хамтран "Топ менежер" сэдэвт богино хугацааны сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас бэлтгэл болон чөлөөнд гарсан 20 гаруй хүнийг хамруулан төгсгөж, тэднийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар дамжуулан төрийн болон аж ахуйн нэгжүүдэд зуучлан ажилд оруулах чиглэлээр ажиллаж байна. Үүнээс гадна Цагдаагийн Ерөнхий газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран "Хүчирхийллийн эсрэг сургагч багш нарыг бэлтгэх сургалт"-ыг зохион байгуулан бэлтгэл, чөлөөнд байгаа 100 гаруй ахмадыг хамрууллаа. Эдгээр ахмадуудад "Хүчирхийллийн эсрэг сургагч багш" гэсэн үнэмлэх олгосон бөгөөд ЦЕГ-аас энэ чиглэлээр зохион байгуулах суртал ухуулга, хүмүүжлийн арга хэмжээнүүдэд тэднийг гэрээгээр ажиллуулах юм.

Асар богино хугацаанд далайцтай ажлуудыг хийсэн нь харгагдаж байна. Энэ бүгдийг амжуулж, хич хэрэг болгосон хөдөлгөгч хүчнүүдийн талаар дурдахгүй юу?

"Монгол цэргийн нэгдсэн холбоо нь удирдах зөвлөлийн 25, бага хурлын 136 гишүүнтэй, нийт 40 гаруй мянган дэмжигчтэй, 13 аймагт салбар холбоо, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын мэргэжлийн болон эмэгтэйчүүдийн 40 гаруй холбоог эгнээндээ нэгтгэн үйл ажиллагаагаа явуулж байна. Эх орныхоо төлөө сэтгэл зүрхээрээ нэгдэж, эх орноо гэсэн чин сэтгэлтэй төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгжүүдийг нэгэн зорилгод нэгтгэн сэтгэл зүрхээрээ ажиллаж байгаа тул бидний ажил үйлс бүтэмжтэй байдаг байх. "Сэтгэл шингэсэн аливаа бүтээл урлаг болж чаддаг" гэсэн үг байдаг даа. Мөн манай өнөөгийн нийгэмд ийм орон зай үгүйлэгдэж байсан бөгөөд тэрхүү орон зайг хэрэгтэй цагт нь нөхөж чадсан учраас ийм амжилтад хүрч байгаа болов уу.

Орон нутаг дахь салбар холбоодын талаар мэдээлэл өгөхгүй юу?

"Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий зэрэг 13 аймагт Монгол цэргийн нэгдсэн холбооны салбар холбоог байгуулаад байна. Эдгээр аймагт зохион байгуулагдаж байгаа ажлууд нь Монгол цэргийн нэгдсэн холбооноос зохион байгуулсан нийт ажлын 26 хувийг эзэлж байгаа юм. Цаашид ойрын хугацаанд бусад аймаг, нийслэлийн дүүргүүдэд салбар холбоодыг байгуулахаар ажиллаж байна.

Гадаад хамтын ажиллагаа хэрхэн өргөжин тэлж, хөгжиж байгаа вэ?

"Үйл ажиллагааны бас нэг гол чиглэл нь гадаадын улс орон, олон улсын байгууллага болон иргэний нийгмийн ижил төстэй зорилго бүхий байгууллага, иргэдтэй хамтран ажиллах явдал юм. Энэ хүрээнд ОХУ-ын Бүх Оросын ахмад дайчдын "Дайчин нөхөрлөл" олон нийтийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээнд Монгол цэргийн нэгдсэн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Удирдах зөвлөлийн дарга, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, "Дайчин нөхөрлөл" байгууллагын нэгдүгээр орлогч дарга, ОХУ-ын Төрийн Думын гишүүн Д.В.Саблин нар 2019 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Москва хотноо гарын үсэг зурлаа. Улаан-Үд хотод болсон ЗХУ-ын хоёр удаагийн баатар, ЗХУ болон Польш улсын маршал К.К.Рокоссовскийн дурсгалын цогцолборын нээлтийн ажиллагаанд холбооны удирдах зөвлөлийн гишүүд оролцлоо. Мөн БНСУ-ын нүдний эмч нарын нийгэмлэгтэй холбоо тогтоож, 2000 гаруй хүнд харааны үзлэг оношилгоо хийлгэн, иргэдийг харааны нүдний шилтэй болгох гэрээ байгуулан ажиллаж байна. "Дэлхийн ахмад дайчдын холбоо", "Энхийг сахиулагчдын холбоо"-нд гишүүнээр элсэх, гадаадын зарим орны ахмадын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар ажиллаж байна.

Цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудаасаа сонирхуулахгүй юу?

"БХЯ, ЗХЖШ, Нийслэлийн ЗДТГ, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгатай хамтран "Эх орноо магтан дууль" сэдэвт дууны хүүхдийн их наадам, гала концертг зохион байгуулахаар төлөвлөж байна. "Монгол цэргийн өдөр"-ийг угтан Үндэсний аюулгүй байдлын асуудлаар "Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хүн амын оюуны дархлааны асуудал" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулаа. Үргэлжлүүлээд "Оюутан цэрэг" хөтөлбөрийн асуудлаар БХЯ, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб, ҮБХИС-ын болон бусад их, дээд сургуультай хамтран хэлэлцүүлэг хийнэ. "Бага дарга нарын холбоо" ТББ-тай хамтран "Цэргийн алба-Миний бахархал" сэдэвт бүсчилсэн уулзалт, Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойн хүрээнд баруун, зүүн хоёр чиглэлд "Ялалтын замаар" сэдэвт авто экспедиц, дээр дурдсан ОХУ-ын "Дайчин нөхөрлөл" холбоотой хамтран "Хамтын ялалт-Энх тайвны төлөө" сэдэвт олон улсын арга хэмжээ зэргийг зохион байгуулаа. Мөн "Олон улсын энхийг сахиулагчдын өдөр"-ийг тохиолдуулан "Монгол Улсын энхийг сахиулагчдын үндэсний анхдугаар чуулга уулзалт"-ыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулах, төрийн болон орон нутгийн байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, хугацаат цэргийн албанд татагдахаар эмнэлгийн үзлэгт орж байгаа залуучуудад гэр бүлийн хүчирхийлэл, архидалт, хар тамхины аюулын талаар ухуулга, сурталчилгаа хийх, эдгээрээс ангид байх хөдөлгөөнийг цэргийн насны залуучуудын дунд өрнүүлэх гээд олон ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Ярилцсанд баярлалаа. Эх оронч үндэсний үзэл, бахархлыг төлөвлөн, ард түмнээ соён гэгээрүүлэх эрхэм үүрэгт тань өндөр амжилт хүсье.

"Баярлалаа, цаашид та бүхнийг манай байгууллагатай нягт хамтран ажиллахыг хүсье. Энэ завшааныг ашиглан уншигч та бүхэндээ 2020 онд ажлын амжилт, эрүүл энхийг хүсэн ерөөе.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

ТЭД ШИНЖИЛДЭГ, ИЛРҮҮЛДЭГ, СУДАЛДАГ, ОНОШИЛДОГ

(Түрүүч нь I нүүрт)

Байгуулагдсан цагаасаа эхлэн үйл ажиллагаа нь өргөжин тэлсээр 1988 онд БХЯ, НАХЯ-ны сайдын хамтарсан тушаалаар Хилийн ба Дотоодын цэргийн шүүх эмнэлэг, эмгэг судлалын тасгийг тус байгууллагатай нэгтгэн зохион байгуулснаар Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудаас гадна Хилийн цэрэг, Аюулаас хамгаалах байгууллага, Цагдан сэргийлэх газар, Хорих байгууллагуудын шүүх эмнэлгийн ажлыг бүхэлд нь хийж эхэлсэн ажээ.

Мөн 1989 оноос Зүүнбаянгийн гарнизоны эмнэлэгт салбар шүүх эмнэлэг, эмгэг судлалын тасгийг байгуулсан зэрэг нь тус байгууллагын түүхийн алтан үе гэлтэй. Эрүүл мэндийн яамны харьяа Эмгэг судлалын үндэсний төв, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Шүүхийн шинжилгээний үндэсний төв гэж бий. Тэгвэл тус байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэсэн ганцхан байгууллага Монголд байдаг нь Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлэг юм. Миний хувьд эмч, ажилтан албан хаагчдаа сурган дадлагажуулах, мэргэжлийн түвшинг нь ахиулах бодлого баримтлан ажиллаж байна. Мөн үйл ажиллагаагаараа төстэй бусад байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, боловсон хүчнийхээ мэдлэг, туршлагыг нэмэгдүүлэх талаар ч анхаарч байна” гэж тус байгууллагын дарга, хошууч Д.Чулуунбаатар онцолсон. Тэр бээр 1997 онд Анагаах ухааны их сургууль, 2005 онд Удирдлагын академийг тус тус төгссөн бөгөөд Анагаах ухааны болон төрийн удирдлагын магистр зэрэгтэй ажээ.

Эмгэг судлал гэдэг нь маш хариуцлагатай ажил ажээ. Тухайлбал, хэн нэг хүн ходоодоо дурандууллаа гэж бодъё. Эмч ходоодноос нь эд авч тус байгууллага руу явуулна. Журмынх нь дагуу Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлгийн лаборатори тухайн эдийг нь шинжлээд онош тогтооно гэсэн үг. Хэрэв онош буруу тогтоовол эрх зүйн хариуцлага хүлээдэг. Өөрөөр хэлбэл, тухайн өвчтөний аль нэг эрхтэнийг хавдартай байна гэж үзвэл шууд зүсэлт хийх, тайрах арга хэмжээ авдаг болохоор алдах эрхгүй мэргэжил юм. Энэ тухай эмгэг судлаач эмч, ахмад Д.Баасансүрэн хэлэхдээ “Бид ерөнхийдөө задлан шинжилгээ, эсийн шинжилгээ, эдийн шинжилгээ хийдэг. Эсийн шинжилгээ илүү нарийн юм. Голдуу умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх мөн биеийн хөндийн энд тэнд хурсан шингэнээс эсийн шинжилгээ авч оношийг тогтоодог. Тухайлбал, нэг өвчтөний уушги устлаа гэхэд усыг нь соруулж аваад манайх руу эсийн шинжилгээнд өгнө. Бид түүнийг нь судлаад хавдрын эс байгаа эсэхийг эсийн



Ахмад Д.Баасансүрэн

түвшинд тогтоодог. Харин эдийн шинжилгээнд бүх мэс заслын оношилгоо багтдаг. Арьсанд нэг овойсон зүйл гарлаа гэхэд, тэр нь юу ч байх магадлалтай учир заавал лабораторийн шинжилгээнд ордог. Хоргүй хавдар гэж оношлогдож байсан ч манайд ирээд шинжилгээнд орсны дараа хортой хавдар байсан нь илэрсэн жишээ хэд хэд бий. Зарим оношлоход бэрх эдийн зургийг аваад гадаадын улс орнуудын эмч нар руу илгээж зөвлөгөө авах тохиолдол ч гардаг. Дэлхийд бүртгэгдсэн болоод бүртгэгдээгүй олон мянган өвчин бий. Тэр бүхэнд бид маш хариуцлагатай хандаж, ёстой л “Долоо хэмжиж, нэг огтолдог гэж болно” хэмээн ярьсан юм. Өнгөрсөн онд гэхэд тус байгууллага 2600 гаруй эдийн шинжилгээ хийж, оношийг нь эцэслэн тогтоосон байна. Харин эсийн шинжилгээний хувьд төсөвтөө баригдаад цөөн авдаг ч 2019 онд хортой хавдар гурвыг илрүүлж, оношийг эрт үед нь тогтоож чаджээ.

Ер нь эмгэг судлалын үйл ажиллагаа сайн явагдаж, шинжилгээг хэр зэрэг нарийн хийж чадна, тэр хэмжээгээр эмнэлгийн мэс заслын хөгжил төдий чинээ урагшилдаг ажээ. “Хэдий үйл ажиллагаа явуулахад техник, тоног төхөөрөмж, орон байрны асуудал хүнд байдаг ч бид хийх ёстой ажилдаа чин сэтгэлээ зориулж, өөрсдөө шалтгаалах бүх зүйлийг хийж ирсэн. Жишээлбэл, миний ширээн дээр байгаа энэ микроскоп аль 1980-аад оных. Яах вэ, ажиллах механизм буюу гэрлийн оптикийн зарчим нь өөрөө хуучрахгүй учир хэрэглэж болоод л байна. Гэтэл сүүлийн үеийн гэлтгүй ихэнх микроскопууд дижиталчлагдсан. Эд, эсэд шинжилгээ хийнгүүтээ зургийг нь авч компьютерт оруулаад хүссэнээрээ шинжлэх боломжтой болсон. Аймгийн төвийн эмч нар гэхэд л шинжилгээний зургаа аваад, эрүүл мэндийн яамны нэгдсэн сүлжээнд оруулах боломжтой байдаг. Гэхдээ манайхаас гарсан оношийг эцсийн онош гэж ойлгож болно. Бид хэзээ ч гаргасан оношиндоо эргэлздэггүй бөгөөд шинжилгээг манай лабораторийн мэргэжилтнүүд маш сайн оношилж чаддаг. Задлан шинжилгээний хувьд эмнэлэгт нас барсан, эсвэл Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу тодорхой заалтуудын хүрээнд хийдэг. Бидний хувьд өвчтөний түүхэнд тулгуурлаж дүн шинжилгээ хийдэг бөгөөд эцсийн оношинд нь шинжилгээ

хийж, онош зөв эсэх талаар шалгадаг. Өөрөөр хэлбэл, оношоо буруу тавиад буруу эмчилсээр байгаад ийм байддалд хүргэв үү, зөв онош тавиад зөв эмчлээд байхад хүндэрсээр байгаад алдчихав уу, эсвэл хийгдэх ёстой эмчилгээ, үйлчилгээг тасалдуулснаас болов уу зэрэг олон хүчин зүйлсийг судалж, шалтгааныг нь тогтоодог. Нэг үгээр хэлбэл, бид эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавьж, цаашид гарч болох доголдоос урьдчилан сэргийлдэг. Тиймдээ ч аль ч эмнэлгийн эмч нараас мэдлэг, чадвараар илүү байж, хяналт тавих ёстой гэсэн зарчмыг бид баримталдаг” хэмээн ахмад Д.Баасансүрэн нэмж онцолсон.

Тэрбээр 2005 онд ОХУ-ын Волгоград хотын Анагаах ухааны их сургуулийг хүний их эмч, 2006 онд АНУ-ын Монтанагийн их сургуульд биеийн бүтэц зүйгээр мэргэжил дээшлүүлж, 2007 онд Хавдар судлалын үндэсний төвд хавдар судлаач эмчээр, 2013 онд анагаах ухааны магистр, 2010 онд эмгэг судлаач эмч, 2015 онд Шүүх эмнэлгийн шинжээч эмч, 2016 онд эс судлаач эмчээр тус тус мэргэжил дээшлүүлсэн Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлгийн тэргүүний ажилтан юм.

Дараагийн онцлох хүн бол эмгэг судлаач, шинжээч эмч С.Наранцэцэг юм. Тэр бээр тус байгууллагад 11 дэх жилдээ ажиллаж байгаа бөгөөд 1992 онд АУИС-ийн эмчилгээний ангийг төгсөөд Зүүнбаянд буюу МАА-ийн 206 дугаар ангид дотрын эмчээр томилогдон ажлын гараагаа эхэлжээ. Мөн 1997-2007 онд Зэвсэгт хүчний 326, 120, 065 дугаар ангийн эмнэлгийн албаны даргаар ажилласан. 2007-2008 онд БНХАУ-ын Шанхай хотын Хуурай замын цэргийн Анагаахын хоёрдугаар их сургуульд уушгины их эмчээр суралцаж төгсөөд тус байгууллагад шинжээч эмчээр одоог хүртэл ажиллаж байна. 2009 онд Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн Мэргэжил дээшлүүлэх институтэд эмгэг судлаач, шинжээч эмчээр мэргэшсэн аж. Тэрбээр удам дамжсан цэргийн хүн бөгөөд түүний аав нь Барилгын цэргийн улс төрийн хэлтсийн дарга байсан хурандаа Н.Самдан бол түүний нөхөр нь УБХИС-ийн Агаарын довтолгооноос хамгаалах тэнхимийн эрхлэгч, хурандаа Д.Эрдэнэ-Очир ажээ. Тэдний хүү Э.Занданхүү нь “Тэмүүжин Өрлөг” дунд сургуулийн анхны төгсөгч бөгөөд өдгөө ОХУ-ын Санкт Петербург хотын Цэргийн инженерийн дээд сургуулийн гуравдугаар дамжааны оюутан. С.Наранцэцэг “Би 2018 онд тэтгэвэртээ гарсан ч дарга маань эргээд албандаа ажиллах санал тавьсанд их баярладаг. Бидний ажил тийм ч амар биш. Хэр баргийн хүн хийгээд байхгүй шүү” гэж онцолсон.



Шинжээч эмч С.Наранцэцэг

Тус байгууллагад хоёр эмгэг судлаач, шинжээч эмч ажиллагчийн нэг нь дэслэгч Д.Мөнх-Оргил. Тэрбээр 2008 онд “Ач” анагаах ухааны их сургуулийг 6 дугаар хороонд өрхийн эмчээр хоёр жил ажилласан ба 2016-2018 онд ЭМШУИС-ийн Мэргэжил дээшлүүлэх институтийг шинжээч эмчээр төгсөж Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлэгт 2018 оны 6 дугаар сараас эхлэн ажиллаж байгаа аж. Өөрийнхөө мэргэжлийн талаар хэлэхдээ “Шинжээч эмч нь шүүх эмнэлгийн шийдвэр гаргадаг. Мэдээж шийдвэр нэг талдаа таалагдана, нөгөө талдаа таалагдахгүй. Таалагдахгүй тал нь юу ч гэж ярьж болно. Тэгсэн ч бид аливаа шийдвэр, оношийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нарийн тогтоож гаргадаг учир эргэлздэггүй. Хэрвээ алдаа гарвал шууд эрүүгийн хариуцлага хүлээдэг эрх зүйн зохицуулалттай” гэсэн юм. Д.Мөнх-Оргил саяхан ОХУ-ын Иркутск хотод шүүх эмнэлгийн чиглэлээр сургалтад хамрагдан туршлага хуримтлуулаад ирсэн аж.

Тус эмнэлгийн зүрх болсон хэсэг нь лаборатори юм. Гэхдээ тоног төхөөрөмжийн хувьд зарим аймгийн төвийн лабораториудаас ч хоцрогдсон гэдгийг мэргэжилтнүүд онцолж байсныг нуух юун. Тус лабораторид ахлах лаборант Н.Цэцэнжаргал, лаборант Ж.Эрдэнэцэцэг нар ажилладаг. Тэд өөрсдийнхөө өдөр тутамд хийдэг ажлыг маш нарийн тайлбарласан юм. Лабораторид аливаа



Дэслэгч Д.Мөнх-Оргил

мэс заслаар авагдсан болон задлан шинжилгээний үед хийгдсэн эдийг шинжлэхээс гадна хэвлийн шингэн, цээжний хөндийн шингэн, умайн хөндий зэрэгт эсийн шинжилгээ хийдэг онцлогтой. Тухайлбал, задлан шинжилгээгээр ирсэн эдэд гадна төрх, ерөнхий байдлаас нь харж, анхны шинжилгээг хийгээд олон төрлийн химийн бодист уусгасны дараагаар зүсэлт хийдэг аж.

Өөрөөр хэлбэл, тухайн эдийн үрэвсэлтэй хэсгээс нь дээж аваад тухайн дээжээ сээтэгт хийж, дараагийн хэсэг рүү дамжуулж, бэхжүүлнэ. Ингэснээр эд яг тэр хэмжээндээ хадгалагдана гэсэн үг. Ингээд бэхжүүлж хонуулсны дараа олон төрлийн уусмал, спиртээр угааж, усгүйжүүлэлт хийнэ. Дараа нь тосгүйжүүлэлтийн дамжлагаар оруулаад лааны тосон дамжлагад шилжүүлж, цутгалтад орсны дараа сая зүсэлт хийхэд бэлэн болно. Хэлбэржсэн эдийг маш нарийн зүсээд нимгэн эд гаргаж аван хатааж, будганд оруулна. Энэ процесс өдөр бүр хэдэн арван удаа явагддаг байна. Дамжлага бүр өөрийн гэсэн тогтоосон маш хатуу цагтай учир цагийг чанд баримталж ажлаа явуулах шаардлагатай байдаг гэнэ. Ганц л хором алдвал шинжилгээ бүхэлдээ бүтэлгүйтэж, буруу онош гарах өндөр магадлалтай тул эд бүхнийг нарийн хяналтдаа байлгах шаардлагатай ажээ. Ингэж зүсэгдсэн эд арван жилээр ч яг хэвэндээ хадгалагддаг гэнэ. Дараа нь шинжилгээтэй холбоотой ямар нэгэн маргаан гарлаа гэхэд он, сар, өдөр, цаг, минуттайгаа бүгд архивлагддаг учир ямар ч асуудал гардаггүй. Мөн ямар нэгэн хавдартай байж магадгүй гэсэн эдийг уусмалд бэхжүүлээд олон жилээр хадгалдаг байна. Өөрсдийнхөө хийдэг ажлыг тэд ийн дэлгэрэнгүй ярьсан юм. Ахлах лаборант Н.Цэцэнжаргал хэлэхдээ “Бид чинь дандаа химийн хорон дунд ажиллаж, амьдардаг хүмүүс. Ганцхан энэ умгар өрөөнд шинжилгээ, дамжлага, зүсэлт, будгаа хийхээс гадна бүртгэл, тэмдэглэгээ хөтлөх зэрэг бүхий л үйл ажиллагаа явагддаг. Та харж байгаа биз дээ, өмнө чинь, хойно чинь, хажуу талд чинь хэдэн арван химийн хортой уусмал, бэлдмэлүүд байгааг. Энэ бүхэн чинь агаарт ууршина, техник, тоног төхөөрөмжүүд



Ахлах лаборант Н.Цэцэнжаргал

нь элдэв туяа ялгаруулна гээд ажиллах орчны талаар тоочвол үнэхээр хүнд. Гэсэн ч бид хүмүүсийн эрүүл мэнд, байгууллагынхаа нэр төрийн төлөө зүтгэсээр байна” гэсэн юм. Тэрбээр төрийн байгууллагад 34 дэх жилдээ ажиллаж байгаа бөгөөд өөрийнх нь үндсэн мэргэжил нь эх баригч ажээ. Эх баригч-бага эмчээр улсад 16 жил ажиллаад 2008 онд тус байгууллагад ирсэн байна. Одоо Н.Цэцэнжаргал нь байгууллагынхаа хамгийн ахмад нь бас хамгийн олон жил ажиллаж байгаа ажилтан. Харин лаборант Ж.Эрдэнэцэцэг 1985 онд Анагаахын дунд сургуулийг сувиллагчийн мэргэжлээр төгсөөд улсын Эмгэг судлал, анатомийн товчоонд лаборантаар 10 гаруй жил ажиллаад хувийн салбар руу шилжсэн ажээ. 2012 оноос Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлэг хэмээх “айл”-ын гишүүн болж, өнөөдрийг хүртэл ажиллаж байгаа аж. Тэрбээр “Хүчтэй химийн хортой орчинд ажилладаг учир бид ажлын зургаан цагаар ажилладаг. Жилээс жилд нийслэлийн хүн ам хурдацтай нэмэгдэж байгаатай



Лаборант Ж.Эрдэнэцэцэг

холбогдуулан эмнэлгийн ачаалал, тэр дундаа мэс заслын тоо ч нэмэгдсээр байгаа юм. Үүнийгээ дагаад бид хоёрын ачаалал ч ихсэж байна. Хүмүүс манай байгууллагыг зөвхөн задлан шинжилгээ хийдэг гэж ташаа ойлгодог. Гэтэл үгүй, дээр дурдсанчлан хариуцлага өндөртэй олон ажлыг бид цөөхүүлээ гэлтгүй нугалдаг. Үүнийг салбарын дарга нар сайтар ойлгоосой гэж хүсдэг” гэсэн юм.

Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлэг хэмээх байгууллагын тухайд сурвалжлахад ийм. Хэдий



Туслах ажилтан ахлах ахлагч Ц.Мөнхбаясах, С.Номин-Эрдэнэ, жижүүр Ө.Хуретбек

том сүрлэг, гоё ганган байргүй ч тэдний хийж байгаа үйлс нь олон мянган иргэнд өвчин, эмгэгээсээ урьдчилан сэргийлэх боломж олгоод зогсохгүй шинжлэн судалж, тогтоох зэрэг маш чухал, хариуцлагатай ажил эрхэлдгийг би сайтар ухаарсан юм. Тус байгууллагын лабораторийн хувьд автомат дамжлагатай болчихвол ажлын бүтээмж, шинжилгээний нарийвчлал улам сайжрах ажээ.

Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлгээс өөр манай улсад эд, эсийг уусмалуудын дундаар гараараа дамжуулдаг лабораторитой байгууллага үлдээгүй гэхээр уншигч танаа нэгэн зүйл бодогдох биз ээ.

Ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

2019 ОН АМЖИЛТ БҮТЭЭЛЭЭР ДҮҮРЭН БАЙЛАА

Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа С.БАТХУЯГ



жил болсон. Энэ хүрээнд багагүй ажил хийсэн нь ойлгомжтой ...

-Улс орон даяараа онцгой ач холбогдол өгч ёслол төгөлдөр, өргөн дэлгэр тэмдэглэлээ. Энэ хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, олон ажил, арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал, Халхын голын дайчдын хөшөөг сэргээн засварласан, энхийг сахиулагчаа алдаршуулж, ахмад дайчдад хүндэтгэл үзүүлсэн, Халхын голын байлдаанд оролцсон дайчдын ар гэрийн төлөөллийг хүлээн авч Засаг даргын талархал, гарын бэлэг гардуулан "Хоймор нутгийн хийморьлог дайчид" чуулга уулзалтыг зохион байгуулсан зэргийг онцолж болно. Түүнчлэн олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа офицер, ахлагч, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагч, ахмад дайчид, Батлан хамгаалах салбарын хуульч тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж буй ажилтан, алба хаагчдыг шагнаж урамшуулсан юм.

Цэрэг татлагын хувьд ...
-4, 10 дугаар сард 23 сум,

нэг тосгонд цэргийн жинхэнэ албанд татагдагчдыг эмнэлгийн урьдчилсан үзлэг, Мөрөн сумын төвд давтан үзлэгт оруулж, цэргийн жинхэнэ албанд тэнцэгчдийг Зэвсэгт хүчний Жанжин штабаас тогтоосон хуваарийн дагуу Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн ангиудад хуваарилсан. Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдалд тулгарч буй бэрхшээл, түүнийг шийдвэрлэх чиглэлээр аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгт албан бичиг хүргүүлэн сумдын Эрүүл мэндийн төвөөс тайлан мэдээг авч дүн шинжилгээ хийн тогтоолын өөрчлөлтөд оруулах саналаа Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. Цэргийн насны залуучуудын өвчлөлтийн судалгааг гарган, эрүүлжүүлэх ажлыг дэс дараатай явуулан аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллаж байна. Түүнчлэн цэргийн жинхэнэ албанд татагдагчдын боловсролын судалгааг гаргаж, аймгийн Боловсрол соёлын

газартай хамтран бичиг үсэг үл мэдэгчдийг зайны сургалтад хамруулснаар цэргийн насны залуучуудын дунд бичиг үсэг үл мэдэгчдийн тоо буурсан.

Цэргийн алба хаагаад ирсэн залуусын ажил эрхлэлтийн байдал ямар түвшинд байна вэ?

-2019 онд цэргийн алба хаагаад ирсэн иргэдэд ажил, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэн аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, МСҮТ-тэй хамтран жилд хоёр удаа ажилд зуучлах сургалтыг зохион байгуулсан. Үүнээс гадна 2019 оны I, II ээлжийн цэрэг татлаар татагдсан алба хаагчдын ар гэрт урилга хүргүүлэн эцэг, эхийн төлөөллийг Цэргийн тангарагийн баярт оролцуулан, Зэвсэгт хүчний 186, Хилийн цэргийн 0245 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцуулсан. Ер нь цэргийн алба хааж байгаа залуусын гэр бүлийнхэнтэй эргэх холбоотой ажиллахыг зорьдог. Мөн орон нутагт байрлаж буй анги, салбарынхантайгаа хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэхийг хичээдэг. 2019 онд гэхэд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн тусгай салбарын үйл ажиллагаатай аймгийн Засаг дарга Л.Ганболдыг танилцуулан найман айлын орон сууцны барихад нь зориулж 820 м³ модон материалыг бэлтгэх зөвшөөрөл олгох, салбарын байрлал руу цэвэр усны шугам татахад нь дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахаар болсон.

Энэ жилийн хувьд Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, "Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэхэд онцгой анхаарч ажиллана.

Хошууч Х.ГАНЗУЛ

Шинэ он гараад удаагүй байгаа энэ мөчид өнгөрсөн оны ажил үйлс амжилт бүтээлийн талаар ярилцлагаа эхлэх үү?

-Юуны өмнө уншигчдад шинэ оны мэнд дэвшүүлж. Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб нь 2019 онд Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Батлан хамгаалах асуудлаар тусгагдсан арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх, "Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх" зорилго дэвшүүлэн ажилласан. Өнгөрсөн онд олон чухал ажлыг хийж хэрэгжүүлэн амжилт бүтээл дүүрэн байлаа. 2019 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 38 ажлаас 35 ажил нь хэрэгжиж, гурван ажил үйлчилгээ хүлээгдэж байгаа бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 92,1 хувьтай байна. Эдгээр ажлаас хамгийн чухлыг нь онцолбол "Орон нутгийн хамгаалалтын тухай" Монгол Улсын хууль 2018 онд УИХ-аар батлагдан гарсантай холбогдуулан орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулж батлууллаа.

Цэргийн штабын гол үүрэг, зорилгын нэг нь орон нутагт Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, үйл ажиллагааг сурталчлах ажил байдаг ...

-Тэгэлгүй яах вэ. Цэргийн штабыг Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг орон нутгийнхаа удирдлага, байгууллага, иргэдтэй холбодог гүүр гэж хэлж болно. 2019 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг

татлага, эмнэлгийн урьдчилсан үзлэгийг 24 суманд явуулах үеэр Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, үйл ажиллагааг 3280 орчим иргэнд сурталчлах ажлыг зохион байгуулсан. Энэ үеэр хүүхэд, залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх, үндэсний бахархлыг төрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг түлхүү явуулахыг зорьсон. Аймгийн "Сод-Эрдэм", "Эрдмийн далай" цогцолбор сургуулиудын ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил олгох зорилгоор сургалт, сурталчилгааг 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, уг сургалтад ахмад дайчин Я.Гомбо, Г.Дамбаравжаа нарыг урьж оролцуулан 1939 оны Халхын голын байлдааны ялалтын тухай сонирхолтой түүхэн дурсамжийг яриуллаа. Соёлын гавьяат зүтгэлтэн Ж.Цогтсугар, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D), хошууч Т.Сүхбаатар нараар "Хүн байхын учир", "1939 оны Халхын голын байлдааны ялалтын түүхэн ач холбогдол" сэдвээр Мөрөн сумын "Эрдмийн далай", "Сод-Эрдэнэ" дунд сургуулийн багш, сурагчдад, Тосонцэнгэл сумын иргэд, дунд сургуулийн сурагчдад сургалтыг зохион байгуулсан. Мөн "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 98 жилийн ойн хүрээнд Хөвсгөл аймгийн Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд "Марш тактик, тусгай бэлтгэлийн аварга тасаг" шалгаруулах тэмцээнийг явууллаа. Ингээд тоочоод байвал нэлээд урт жагсаалт гарах байх.

Өнгөрсөн онд Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ой тохиосон онцлог

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХЭМЖИЛ ЗҮЙН ДҮРЭМ

"Зэвсэгт хүчний хэмжил зүйн дүрэм"-ийн төслийг ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба уг дүрмийг Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/393 дугаар тушаалаар баталлаа.

Энэхүү дүрмийн зорилго нь Зэвсэгт хүчний хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах, Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, харьяа аж ахуйн нэгж, байгууллагад ашиглагдаж байгаа зэвсэглэл, цэргийн техникийн бэлэн байдал, найдвартай ажиллагааг хангах үйл ажиллагааг зохион байгуулж, албан тушаалтнуудын эрх, үүргийг тодорхойлоход оршино.

Зэвсэгт хүчний хэмжил зүйн хангалт гэдэг нь Зэвсэгт хүчний хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах үйл ажиллагааг үнэн зөв, шуурхай, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх, зэвсэглэл, цэргийн техникийн хэмжлийн норм, дүрэм, заавар, стандартыг шинжлэх ухааны болон зохион байгуулалтын үндэслэлтэй боловсруулж хэрэглэх цогц арга хэмжээ бөгөөд Монгол Улсын Батлан хамгаалах, аюулгүй байдлын хэмжил зүйн хангалтын үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг болно.

Зэвсэгт хүчний хэмжил зүйн хангалтын үндсэн зорилго нь Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын байлдах чадвар, байлдааны бэлэн байдлыг хангах, зэвсэглэл, цэргийн техникийг зориулалтаар нь осол гэмтэлгүй ашиглах, бүх төрлийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахад чиглэгдэнэ.

"Зэвсэгт хүчний хэмжил зүйн дүрэм"-ийг боловсруулахдаа:

1."Хэмжил зүйн тухай хууль"-ийн 17 дугаар зүйлд Засгийн газрын гишүүн хэмжил зүй, хэмжлийн эталоныг бий болгох, хөгжүүлэх, техникийн зохицуулалт, стандарт боловсруулах, дүрэм, журмыг батлах, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах бүрэн эрхийг

хэрэгжүүлэх заалтыг үндэслэн боловсруулсан.

2.Монгол Улсын батлан хамгаалахын тогтолцоо шинэчлэгдэж байгаатай холбогдуулан дэлхийн орнуудын цэргийн байгууллагын хамтын ажиллагааны чиглэлтэй уялдуулан хэмжил зүйн хангалтын үндсэн үүрэг, үйл ажиллагааг зохицуулах зорилго агуулсан.

3.Хэмжил зүйн шинжлэх ухаан, техник технологийн хөгжил, Зэвсэгт хүчинд нийлүүлэгдэж байгаа зэвсэглэл, цэргийн техникийн хүчин чадал боломжийг харгалзан эталон хэмжих хэрэгслийг нэмэгдүүлэх бодлогыг баримталсан.

Зэвсэгт хүчний хэмжил зүйн дүрмийн агуулга нь:

1.Нийтлэг үндэслэл;
2.Зэвсэгт хүчний хэмжил зүйн хангалтын зохион байгуулалт;
3.Зэвсэгт хүчний удирдах албан тушаалтны хэмжил зүйн асуудлаар хүлээх үүрэг;
4.Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэмжил зүйн албаны албан тушаалтны үндсэн үүрэг, эрх;
5.Хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт, тохируулга хийх;
6.Хүлээх хариуцлага гэсэн зургаан бүлэгтэй.

Зэвсэгт хүчний хэмжил зүйн хангалтын зохион байгуулалтын хувьд:

Зэвсэгт хүчний хэмжил зүйн үйл ажиллагааг Батлан хамгаалахын Ерөнхий хэмжил зүйч, ЗХЖШ-ын Ар талын газрын Хэмжил зүйн алба, Хуурай замын болон Агаарын цэргийн командлалын хэмжил зүйн ахлах мэргэжилтэн, мотобуудлагын бригад, хороо, төрөл, тусгай мэргэжлийн хорооны хэмжил зүйч-инженер, Зэвсэгт хүчний нэгдсэн лаборатори зохион байгуулж хэрэгжүүлнэ.

БХЯ-ны харьяа аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, ЗХЖШ-ын Ар талын газрын дарга, Хуурай замын болон Агаарын цэргийн командлагч, мотобуудлагын бригад, хороо, төрөл, тусгай мэргэжлийн анги, салбарын захирагч, хэмжил зүйн ерөнхий удирдлагыг хэрэгжүүлж, хэмжил зүйн алба, албан

тушаалтны ажиллах нөхцөл, боломжийг хангана.

Мотобуудлагын бригад, хороо, төрөл, тусгай мэргэжлийн анги, байгууллагын захирагчийн орлогч-ар талын дарга нар хэмжил зүйн алба, албан тушаалтныг шууд удирдана.

Зэвсэгт хүчний хэмжил зүйн албаны дарга, ерөнхий хэмжил зүйч нь ЗХЖШ-ын Ар талын газрын даргад шууд захирагдана. Зэвсэгт хүчний хэмжил зүйн албаны дарга, ерөнхий хэмжил зүйч нь Хуурай замын болон Агаарын цэргийн командлалын хэмжил зүйн ахлах мэргэжилтэн, мотобуудлагын бригад, хороо, төрөл, тусгай мэргэжлийн хорооны хэмжил зүйч-инженер, Зэвсэгт хүчний хэмжил зүйн лабораторийг мэргэжлийн удирдлагаар удирдана.

Зэвсэгт хүчний Хэмжил зүйн албаны дарга нь Хуурай замын болон Агаарын цэргийн командлалын хэмжил зүйн ахлах мэргэжилтэн, мотобуудлагын бригад, хороо, төрөл, тусгай мэргэжлийн хорооны хэмжил зүйч-инженер, Зэвсэгт хүчний хэмжил зүйн лабораторийн даргын албан тушаалд томилуулах саналаа холбогдох байгууллагуудын хүний нөөцөд танилцуулж шийдвэрлүүлнэ.

Зэвсэгт хүчний хэмжил зүйн албаны мэргэжилтнүүдийг Стандарт, хэмжил зүйн газрын хэмжил зүйн мэргэжлийн сургалт, дамжаа, гадаад улс орны цэргийн академи, дээд сургуульд хэмжил зүйч-инженер мэргэжлээр, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн инженер, ар талын мэргэжлийн сургалтын хөтөлбөрт 2-3 кредит цагийн "Хэмжил зүйн бэлтгэл" хичээлээр сургаж бэлтгэнэ. Хэмжил зүйн мэргэжил дээшлүүлэх сургалтыг гурван жил тутамд нэг удаа Стандарт, хэмжил зүйн газартай хамтран зохион байгуулна.

Хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт, тохируулга хийхдээ:

Улсын баталгаажуулалтад заавал хамрагдах Зэвсэгт хүчний хэмжил зүйн лабораторийн эталон хэмжих хэрэгслийг Стандарт хэмжил зүйн газрын хэмжил зүйн лабораториудад шалгалт,

баталгаажуулалт, тохируулгыг хийлгэж, үйл ажиллагаа явуулах эрх, итгэмжлэл авна.

Зэвсэгт хүчний эталон нисэхийн ба пуужин шалгах хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалт, тохируулгыг гадаадын цэргийн хэмжил зүйн лабораториудад гэрээ байгуулж хийлгэнэ.

Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын хэмжих хэрэгсэлд хийх шалгалт, баталгаажуулалт, тохируулгыг хэмжил зүйн мэргэжлийн улсын шалгагч нар хэрэгжүүлнэ.

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын хэмжих хэрэгслийн туршилт, засварын ажлыг Зэвсэгт хүчний нэгдсэн лаборатори хэрэгжүүлнэ.

Мотобуудлагын бригад, хороо, төрөл, тусгай мэргэжлийн хорооны хэмжил зүйч-инженерийн үүрэг:

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн хэмжил зүйн үйл ажиллагаа, хэмжих хэрэгслийн ашиглалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

-Шинэ загварын зэвсэглэл, цэргийн техникийн хэмжих хэрэгслийг эзэмших, зөв ашиглахад бие бүрэлдэхүүнийг сургах;

-Зэвсэглэл, цэргийн техникийн хэмжих хэрэгслийн засвар, баталгаажуулалтын ажлыг зохион байгуулах;

-Хэмжих хэрэгслийг баталгаажуулах болон хэмжил зүйн үйл ажиллагаатай техникийн систем, тоног төхөөрөмжийн нэгж хэмжигдэхүүнийг хэмжлийн эталонтой харьцуулж үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлох;

-Хэмжих хэрэгсэлд засвар баталгаажуулалт хийхэд зарцуулах материал, сэлбэг хэрэгсэл, норм, хугацааны саналыг боловсруулах;

-Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, цэргийн нэгтгэл, ангийн мэдээллийн санд мэдээлэл оруулах;

-Хэмжил зүйн норм дүрмийг биелүүлэх, хэмжлийн аргыг баталгаажуулах, эталон нэгж хэмжигдэхүүн, стандарт загвар, хэмжих хэрэгсэл болон хэмжилд тавигдах зайлшгүй шаардлагыг

сахих байдалд хэмжил зүйн хяналт шалгалт зохион байгуулах;

-Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн хэмжил зүйн хангалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх;

-Ашиглалтын хугацаа дууссан хэмжих хэрэгслийг актуулах, данснаас хасуулах саналаа Хуурай замын болон Агаарын цэргийн командлалын хэмжил зүйн ахлах мэргэжилтэнд уламжлан шийдвэрлүүлэх;

-Тогтоосон хугацаанд хэмжих хэрэгслийн захиалгыг өгөх, тэдгээрийг хүлээн авах, хуваарилах, хадгалах;

-Хэмжих хэрэгслийн бүртгэл тооцоог хариуцан судалгаа, тооллого хийх;

-Зэвсэглэл, цэргийн техникийн хэмжил зүйн үйлчилгээг зохион байгуулж хэрэгжүүлэх;

-Хэмжил зүйн хангалтын асуудлаар цэргийн нэгтгэл, анги, салбарын бие бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулах;

-Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн хэмжил зүйн орон тооны хэрэгслийн хангалтын норм боловсруулахад шаардагдах мэдээллийг гаргаж өгөх;

-Цэргийн ангийн объект, зэвсэг, галт хэрэгсэл, шатахууны агуулахын аянга зайлуулагчийн газардуулгын эсэргүүцэлд хэмжилт хийлгэж дүгнэлт гаргуулах зэрэг хамаарна.

Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/393 дугаар тушаалаар "Зэвсэгт хүчний хэмжил зүйн дүрэм" батлагдсантай холбогдуулан уг дүрмийг сурталчлах, холбогдох бүрэлдэхүүнээр судлуулах, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын хэмжил зүйн хангалтын үйл ажиллагаанд мөрдүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж хянаж, шалгаж ажиллах хэрэгтэй байна.

Батлан хамгаалахын хэмжил зүйг хөгжүүлэх талаар үе шаттай тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа Монгол Улсын Их хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Батлан хамгаалахын сайдын болон ЗХЖШ-ын даргын зөвлөлийн гишүүдэд гүн талархал илэрхийлнэ.

Бэлтгэл хурандаа Ц.ДОРЖХҮҮ



Яг одоо ... юунаас болж...



Таныг өглөө эртлэн босож, халуун кофегео уугаад ажил руугаа гарч байх агшинд дэлхийн аль нэг цэгт зэвсэгт мөргөлдөөн, цус асгаруулсан тулалдаан болсоор байдаг. Эдгээр мөргөлдөөн, тулалдааны ихэнх нь жилээс ч илүү хугацаанд үргэлжилж байгаа гэдэгт та итгэх үү. Та бүхэнд яг одоо байлдааны идэвхтэй ажиллагаа явагдаж байгаа зэвсэгт мөргөлдөөн, дайнууд болон ямар улс, бүлэглэл юуны төлөө оролцож байгаа талаар товчлон хүргэе.

АЛЖИР

2002 оноос гаднын дэмжлэгтэй террорист бүлэглэлүүдтэй тасралтгүй тэмцэж байгаа ба тэдний энэхүү үйл ажиллагаанд АНУ болон Европын холбоо санхүүгийн хэлбэрээр дэмжлэг үзүүлдэг. Тус тэмцэл хэзээ хүртэл үргэлжлэх нь тодорхойгүй бөгөөд 6000 гаруй хүний амь насыг авч оджээ

АРМЕН-АЗЕРБАЙДЖАН

1990-1994 онд өрнөсөн байлдааны ажиллагааны хор уршиг, үр дагавар одоог хүртэл хэвээр байна. Хэдийгээр Киргизийн нийслэл Бишкек хотноо хоёр улсын тэргүүн "Зэвсэг үл хэрэглэх" гэрээг байгуулсан ч тус байлдааны ажиллагааг жижиг хэмжээнд, бие биеэ өдөөн хатгасан хэлбэрээр тогтмол явуулж байна.

АФГАНИСТАН

Тус улсад болж буй үйл явцын талаар өдөр бүр олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гарч байдаг тул бидэнд аль хэдийн хэвийн мэт зүйл болжээ. Анхандаа эрх мэдлийн төлөө хоёр хүчний тэмцэл байсан бол одоо Исламын улс террорист бүлэглэлтэй тулалдах болсон. Мөн олон жилийн дайн, самууны хөлд нэрвэгдэж байгаа Афганистаны эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол зэрэг бүхий л салбар уналтад орж, хүүхдүүд ухаан орсон цагаасаа тоглох бус байлдаж байна.

ИРАК

2003 онд АНУ-ын тэргүүлсэн эвслийн цэрэг Ирак руу халдан довтолж, Саддам Хусейны дэглэмийг нураасан

цагаас эхлэн тус улсад буун дуу гараагүй өдөр гэж үгүй. Учир нь эвслийн цэргүүдийн эсрэг болон суннит-шийтийн мөргөлдөөн байнга явагдахын зэрэгцээ 2011 оны Сирийн иргэний дайны нөлөөгөөр хүчирхэгжсэн Исламын улс зэвсэгт бүлэглэл Иракийн нэлээдгүй хотуудыг өөрсдийн хяналтад байлган Засгийн газрынх нь эсрэг байлдаж байна.

ИРАН

2020 он гарахтай зэрэгцэн дэлхий нийтийн анхаарлын төвд орсон тус улсын хувьд олон улсын тавцанд ганцаардах хандлагатай байна. Учир нь АНУ тусгай ажиллагаа явуулж генерал Касем Сулейманийг хороосны хариуд Иракт байрлах Америкийн цэргийн баазууд руу пуужин харваж, цохилт үзүүлсэн. Тус пуужингийн цохилтод хэдийгээр Америкийн нэг ч иргэн, цэргийн алба хаагч эрсдээгүй боловч Иран улс АНУ-аас айх зүйлгүй гэдгээ харууллаа гэж олон улсын шинжээчид тайлбарлаж байна. Мөн энэхүү тэмцэлд Ираны босогчид нэгдсэн бөгөөд хэдхэн хоногийн өмнө Америкийн цэргийн баазууд руу пуужин харвасан нь асуудлыг улам хурцатгаж, эдийн засгийн бүх талын хориг тавих болно гэдгээ Дональд Трамп мэдэгдэж бусад улсыг адилхан арга хэмжээ авахыг ч уриалсан юм.

КАМЕРУН

2018 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Африкийн Камерун улсын иргэд нийслэл Яунде хотноо үндэсний баяраа тэмдэглэж, цэргийн ёслолын жагсаал алхаж байх үед англи хэлтнүүд амьдардаг дүүрэгт нь салан тусгаарлагчид мужийн захирагчийг барьцаалж, цагдаагийн алба хаагч нартай буудалцсан үйл явдал болсон. Учир нь 2016 оны сүүлчээс эхлэн Камеруны англи хэлт цөөнхийн амьдардаг мужуудад хүчирхийлэл газар "авсан" байна. Тэд өөрсдийгөө олон жилийн турш франц хэлтэн олонход дарлуулж байгаа гэж үздэг юм. Тэднийг эсэргүүцлийн тайван жагсаал хийхэд нь цэргүүд гал нээж, тосгодыг нь шатаасан нь иргэний дайн руу түлхсэн гэж үздэг. Энэхүү дайны улмаас 430 мянган иргэн орон гэрээ орхин дүрвэсэн аж.

КОЛУМБ

2016 онд Колумбын Засгийн газар, Колумбын Хувьсгалт зэвсэгт хүчний удирдагчид Картахен хотноо энхийн гэрээнд гарын үсэг зурж, тус улсад 52 жил үргэлжилж, 260 мянган хүний аминд хүрсэн иргэний дайн эцэс болсон. Тухайн үед дэлхийн хэвлэлүүд энэхүү үйл явдлыг "түүхэн" хэмээн онцолж, энх тайван тогтож, сайн цаг ирж байгаа талаар бичиж байв. Гэвч энэ үйл явдалтай давхцан өөр нэг зэвсэглэсэн бүлэглэл бий болж тодорхой газар нутагт өөрсдийн хяналтыг тогтоон Засгийн газрынхаа эсрэг байлдаж байна.

ЛИВИ

2011 онд Муаммар Каддафигийн дэглэмийг унагах иргэний дайны дараа Үндэсний Ерөнхий конгресст эрх мэдлээ булаацалдсан бүлэглэлүүд гарч ирэн Ливийн иргэний дайны хоёрдугаар үеийг эхлүүлсэн юм. Үр дүнд нь НУБ-ын хүлээн зөвшөөрдөг нэг ч Засгийн газар хүлээн зөвшөөрөгдөөгүй ч өөрсдийгөө Ливийг удирдах ёстой хэмээн үздэггүй цөөнгүй Засгийн газар бий болсон.

ПАКИСТАН-ЭНЭТХЭГ

Их Британиас тусгаар тогтносны дараахан Пакистан, Энэтхэгийн хилийн бүсэд оршдог Жамму болон Кашмирын бүс нутаг нь тус хоёр улсын хооронд маргаан үүсэх гол шалтгаан болжээ. Кашмирын хүн амын дийлэнх нь лалын шашинтнууд байсан боловч хинду шашин шүтдэг бүс нутгийн захирагч Махаража Хари Сингх бүх ардын санал хураалт явуулахаас татгалзаж, Жаммуг Кашмирын хамт Энэтхэгийн нэг хэсэг хэмээн

зарлажээ. Энэхүү явдал нь 1947-1949 онд өрнөсөн дайны эхлэл болсон бөгөөд үүний уршгаар Кашмир хоёр хуваагдсанаар дууссан хэдий ч талуудын харилцаа таарамжгүй хэвээр байлаа. Улмаар 1965 болон 1971 онд хоёр удаа дайн дэгджээ. 1980-аад оны сүүлчээр Кашмирт лалын шашны уриа лоозон дор "Энэтхэгт эзлэгдсэн Кашмирыг чөлөөл" гэсэн шаардлага тавьсан террорист бүлэглэлүүдийн үйл ажиллагаа идэвхжиж эхэлсэн байна. 1999 онд хоёр орны хооронд "Каргилийн дайн" гэж нэрлэгдсэн дөрвөн зэвсэгт мөргөлдөөн болжээ. 2003 онд энхийн хэлэлцээр байгуулсан боловч аль аль тал нь байнга тус хэлэлцээрээ зөрчдөг ба дайн гарч болзошгүй "халуун цэг" гэж үздэг байна.

ПАЛЕСТИН БОЛОН ИЗРАИЛЬ

Иерусалим бол дэлхийн хамгийн маргаантай газруудын нэг. Израилийн Засгийн газар тус хотыг бүхэлд нь улсынхаа нийслэл гэж үздэг. Харин палестинчууд мэдэгдэхдээ "1967 онд Ойрх Дорнодын дайны үеэр Израилийн цэргүүд Зүүн Иерусалимыг хууль бусаар булаан эзэлсэн. Энэ хот бол Палестины ирээдүйн төрт улсын нийслэл" гэдэг. Иерусалимын асуудлаарх Израилийн байр суурийг олон улс ч дэмждэггүй юм. Сөргөлдөгч талууд харилцан бие бие рүүгээ пуужин харвах, бөмбөгдөх зэрэг байлдааны идэвхтэй ажиллагааг тогтмол явуулсаар байна.

СИРИ

2011 онд Сири улсын эрх баригчдын авлига, хээл хахуульд баригдсан бурангуй дэглэмийн эсрэг тэмцэхээр Тунис иргэд

"Arab Spring" буюу "Арабын хавар" хөдөлгөөнийг эхлүүлсэн нь өнөөг хүртэл үргэлжилсэн иргэний дайны эхлэл болов. Тус дайны улмаас 50 мянга орчим хүн амь эрсдэж, зургаан сая хүн эх орноосоо дүрвэж, 12 сая гаруй иргэн орон гэрээ алдсан ба дүрвэж явахдаа амиа алдсан иргэдийн тоог гаргах боломжгүй юм. Сирийн иргэний дайны ард дэлхийн хүчирхэг гүрнүүдийн ашиг сонирхол байгаа нь хэдийнээ тодорхой болсон.

УКРАИН

2014 оны 4 дүгээр сараас эхлэн Украины Донецк, Луганск мужуудад дайны гал ассан бөгөөд сар хүрэхгүй хугацааны дараа эдгээр муж бүх нийтийн санал асуулга явуулж Бүгд Найрамдах Донецк, Бүгд Найрамдах Луганск улсууд тусгаар тогтнолоо тунхагласан юм. Өөрсдийгөө тунхагласан бүгд найрамдах улсын удирдагч нар Украины армийг нутаг дэвсгэрээс гаргахыг шаардаж зэвсэгт тэмцлийг эхлүүлсэн. Энэхүү мөргөлдөөний улмаас 3500 гаруй энгийн иргэний амь нас хохироод байна.

Дээр дурдсан дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа зэвсэгт мөргөлдөөн, дайнуудаас гадна намжмал байдалтай байгаа хэдий ч хэзээ ч дайны байдалд шилжих магадлалтай олон үйл явдал байгааг хэлэх нь зүйтэй. Тухайлбал, иргэний дайны хөлд нэрвэгдээд удаж байгаа Өмнөд Судан, алан хядах террорист бүлэглэлүүдтэй удаан хугацаанд тэмцэл явуулж байгаа Филиппин, засаглалын хямрал нүүрлэсэн Венесуэл, Египет зэргийг дурдаж болно.

КП В УКРАИНЕ

ЦЭРГИЙН ЗАРДЛЫН ТАЛААР ТОХИРОЛЦОНО



АНУ-ын цэргийн баазуудыг БНСУ-ын нутаг дэвсгэрт байлгахтай холбоотой батлан хамгаалахын зардлыг тодорхойлох хоёр улсын хэлэлцээнд тодорхой ахиц дэвшил гарсан тухай Өмнөд Солонгосын төлөөлөгчдийн тэргүүн Чон Ун Бо Вашингтон хот руу нисэхийнхээ өмнө мэдэгдсэн байна. Түүний хэлснээр "Одоогийн байдлаар талууд нэлээд ахиц дэвшил гаргаж, хэд хэдэн уулзалтын үеэр холбогдох асуудлын талаар нэгдсэн ойлголтод хүрсэн гэж үзэж байна. Бид харилцан буулт хийх үндсэн дээр гэрээг аль болох хурдан байгуулж, БНСУ, АНУ-ын цэргийн холбоог бэхжүүлэхээр ажиллаж байна" гэж тэр бээр мэдэгджээ.

Цагаан ордны зүгээс Америкийн цэргүүдийг нутагтаа байлгахад гаргадаг зардлынхаа хувь хэмжээг өсгөхийг 2018 оноос хойш БНСУ-аас шаардаж байгаа юм. АНУ нь БНСУ-д байрлаж байгаа 28 мянган цэргийн зардалд жил бүр таван тэрбум ам.доллар зарцуулдаг бол БНСУ зардлаа өнгөрсөн онд 8,2 хувиар нэмэгдүүлж, 1,04 их наяд вон буюу 915 сая ам.доллар болгосон ч Цагаан ордны хувьд энэ нь хангалтгүй байгаа аж.

ТАСС

ЦӨМИЙН ГЭРЭЭГ ДАГАЖ МӨРДӨХИЙГ УРИАЛЛАА

Франц, Герман, Их Британийн удирдагчид 2015 онд байгуулсан цөмийн гэрээг дагаж мөрдөхийг Иран улсад уриалж хамтарсан мэдэгдлийг өнгөрсөн ням гараг гаргасан байна. Тус мэдэгдэлд 2018 онд АНУ цөмийн гэрээнээс гарсан нь харамсалтай

шийдвэр болсныг онцлоод, Иран улсад эдийн засгийн нэмэлт хориг арга хэмжээ авснаар үүсэх үр дагаварт санаа зовниж байгаа талаар онцолсон байна. Түүнчлэн 2019 оны 7 дугаар сараас хойш Иран улсад гэрээнд заагдсан үүргүүдээ биелүүлэхгүй байгааг дурдаад,

гэрээг зөрчсөн үйлдлүүдээ зогсоож, дагаж мөрдөхийг уриалжээ. Ийм мэдэгдэл гаргах болсон шалтгаан нь энэ сарын эхээр Иран улс уран баяжуулалтын хязгаарыг дахин мөрдөхийг гэдгээ зарласантай холбоотой юм.

ТАСС

ДӨЧИН МЯНГАН ШИРХГИЙГ ЗЭВСЭГЛЭЛД ОРУУЛНА



ОХУ-ын Зэвсэгт хүчин 2020 онд нэлээд тооны шинэ зэвсэглэл, техникүүдийг үйл ажиллагаандаа ашиглана. Түүний дотор тоо, ширхгийн хувьд хамгийн олон хэмжээтэйгээр

нэвтрэх зэвсэг нь "АК-12" автомат юм. Тус автомат нь "Калашников" концернийн "Ратник" төслийн хүрээнд зохион бүтээгдсэн бөгөөд

Тактик, техникийн өгөгдөхүүн:

Калибр-5,45 мм
Жин /магазингүй/-3,2 кг
Гол төмрийн урт-415 мм
Хурд-650 сум /1 минутад/
Хараалах холын зай-1000 метр
Ашигтай тусгал-600 метр

ТАСС

Нүүрийг бэлтгэсэн ахмад Э.ОЧУУ



Хазарачуудын олноор байрладаг Бамиянд жагсаал болж байлаа, 2008 он

М.Буянбадрах: ХАЗАРА ҮНДЭСТНИЙ ДУНД ДӨРВӨН ХОНОГ АМЬДАРСАН

Бид таныг нэгэн сонирхолтой эрхэмтэй сониньхоо хуудсаар дамжуулан “уулзуулах” гэж байна. Тэр бээр олон тодорхойлолтын эзэн. Нэгдүгээрт, “Дэлхийн монгол айл” төслийн хүрээнд дэлхийгээр тархсан монгол угсаатнаа эрж хайж, 10 гаруй баримтат киног бүтээсэн. Хоёрдугаарт, Монгол орны байгаль, зэрлэг амьтдын тухай “Хүрээлэн” төслийг хэрэгжүүлж, үүгээрээ мэргэжлийн сэтгүүл зүйг дэмжигч “Балдорж сан”-гийн 2019 оны Гранпри буюу Шилдгийн шилдэг сэтгүүлч. Гуравдугаарт, тэрээр манай сонины ахмад сэтгүүлч, доктор Д.Мархаахүүгийн хүү. Аав шигээ сэтгүүлч болох мөрөөдөл нь “Улаан од” сонины редакцияас эхлэлтэй гэдгээ нэрээ мэдэлцэж уулзсан даруйдаа онцлон хэлнэ лээ. Ингээд сэтгүүлч М.Буянбадрахтай элэг нэгт хазарачуудын тухай ярилцсанаа хүргэж байна. Дүгнэлтийг өөрт тань үлдээе.

дахь ИБНАУ-ын Элчин сайдын яамнаас визээ авах гэж “бөөн ажил” болсон. “Баримтат киноны ажлаар явна” гээд хэлчихсэн чинь “Хэдэн сараар судална” гээд сүйд болов. “Буруу ярьчихжээ” гэж учирлаж хэлээд ч ойлгодоггүй. Аз болоход Гадаад харилцааны яамны нот бичиг авч явсан маань их хэрэг болсон шүү. Ингээд Энэтхэгээр дамжин Кабул хотод ирэхэд интернэтээр холбогдсон эцнээ танил Хуссейн “Сайн байна уу” гээд биднийг угтлаа. Биднийг

**ТӨСӨӨТЭЙ
МОНГОЛ, ХАЗАРА ҮГ**

хабиргаа – хавирга
алгаа – алга
украа – ухархай
хайчи-хайч
гачар – хацар
толгай – толгой
гоол – гол
таяаг – тааг
горияа – хороо
хайру – хайр
көнжила – хөнжил
агай – авгай
авга – авга
нагаги – нагац
яаса – ёс
нома – үсэг
элчи – элч
чээжи-цээж
шигай-шагай

таны нэвтрүүлгээр гарсан ...

–Бамиян явахаар үүрээр бослоо. Газар хол, зам бартаатай, бас зам зууртаа паштун нарын амьдардаг тийм ч тайван бус нутгаар дайрах тул эртэлсэн хэрэг. Гадаа биднийг авч явахаар Халифа хэмээх хазара жолоочтой “Тоёота” микро автобус зогсож байна. Афганистанд жирийн автомашин олно гэдэг амаргүй. Монголын хээр хөдөө тааралдах баргийн нэг овооноос сүртэй гээд хэлчихээд залсан хэрэг болохгүй. Олонх микро автобус чанга яригчтай, ихэнх нь шашны уриа бүхий том ногоон туг дэрвүүлж, хүний нүд торох газар болгонд нь цацаг, жинс сагсайлгаж, наалт зүүлт гялалзуулдаг юм билээ. Манайд сонгуулийн үеэр л нэг иймэрхүү машинууд хөлхдөг биз (инээв). Бамиян мужийн төв нь Кабулаас чанх баруун хойшоо шулуун явбал 125 километр. Уулын замын нугачааг тойрьё

Эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгшид голдуу юм. Манай нэвтрүүлгийн багийнхны хазара иргэдийн төлөөлөл болгон гаргасан Хеди Доди нь энэ нутгийн жирийн нэгэн эр. Шоронд байхад нь талибууд ахыг нь хөнөөчихсөн гунигт түүхийн эзэн. Шоронгоос гарч ирээд заншил ёсоор бэргэн эгчийгээ гэргий болгон авч суусан, өнөр өтгөн гэр бүлээ тэжээх үүрэгтэй залуу. Тэрээр зундаа хот руу орж хөлсний ажил хийж, хураасан мөнгөөрөө ам бүлээ тэжээнэ. Биднийг очиход түүний эхнэр гол дээр юм угаахаар явсан байв. Энд эмэгтэйчүүдийн хувьд гол дээр юм угаах гэдэг нь утас, зурагт, сонин хэвлэл, театр, интернэт зэрэг олон харилцаа холбоог орлодог нь тодорхой харагдана лээ.

Аж төрөх ёс нь онцгой санагдсан ...

–Тийм ээ. Нэгд, хөгжил, хоёрт шашнаас шууд хамаарч байгаа биз. Хазара үндэстэн зөвхөн Афганистанаар хязгаарлагдахгүй. Пакистан, Иранд ч цөөнгүй амьдарч байгаа. МҮОНТ-ийн сэтгүүлч Д.Оюунчимэг Пакистанд байгаа хазарачуудын талаар нэвтрүүлэг очиж бэлтгэж байсныг тод санаж байна. Уг нь Афганистанд очдог гаднын хэвлэлийнхэн хамгаалалтын баг авдаг юм билээ. Бид яах вэ дээ, омголон залуу ч явцгааж, юун хамгаалалт. Гэхдээ би танд 10 жилийн өмнөх үдийг ярьж байгааг ойлгоорой. Одоо бол хазарачуудын цагийн байдал харьцангуй сайжирсан тухай гаднын хэвлэл мэдээллийн хэрэгслээс уншиж байна.

Та нар Афганистанд хэд хоносон бэ?

–Дөрөв. Хамгийн чухал нь энэхүү аяллын дараа манай багийн гишүүн Д.Сайнбаярын санаачилга, БСШУЯ-ны дэмжлэгтэйгээр Афганистанаас анх удаа гурван хазара монгол оюутан МУИС-д суралцсан.

Харин өдгөө та “Хүрээлэн” төслөөрөө эх орныхоо үзэсгэлэнт газруудыг тольдон үзүүлж байна. Монголын хамгийн олон үзэгчтэй нэвтрүүлгээр шалгарсан байсан ...

–Би эрж хайхын зовлонтой хүн. Дэлхий дээрх

монголчуудынхаа тухай нэвтрүүлэг бэлтгээд дууссаны дараа 2013 оны намраас эх орныхоо онгон байгаль, үзэсгэлэнт газар нутаг, ховор ан амьтан, жигүүртэн шувуудын талаарх нэвтрүүлгийг хэсэг нөхдийнхөө хамт бэлтгэсэн. Өнгөрсөн хугацаанд Монгол оронд тэмдэглэгдсэн 138 зүйл амьтны 70 орчмыг, 500 орчим зүйл шувуудын 200 гаруйг, 22 зүйл мөлхөгчийн 8, зургаан зүйл нутагтны бүгдийнх нь гэрэл зургийг авсан байна. Жилийн дөрвөн улиралд цастай, бороотой, шуургатай, нартай олон өдөр хоногуудыг хээр хөдөө өнгөрүүлж дээ. Мориор, онгоцоор, завиар, тэмээгээр, явганаар ч их явлаа. Мөн монгол адууны талаар нэвтрүүлэг бэлтгэж гэж ОХУ, БНСУ, Вьетнам улсад очиж байлаа. Дайны жилүүдэд эдгээр оронд монгол адуу очсон түүх байдаг учраас тэр. Энэ нэвтрүүлгээ хараахан гаргах болоогүй.

Та манай цэргийн нэрт сэтгүүлч Д.Мархаахүүгийн хүү. Тиймээс цэргийн сонин таны эцнээ танил бөгөөд уншиж өссөн хэвлэл нь гэж ойлгож болох уу?

–Тэр мэдээж шүү дээ. Миний аав 1980-аад оноос “Улаан Од” сонинд сурвалжлагчаас хэлтсийн дарга, орлогч эрхлэгч хүртэл дэвшин ажилласан. Б.Чантуу, А.Баярмагнай эрхлэгчийн оргил үед гэж хэлж болно. Манай аавын гараас Т.Ганди, Ц.Элбэгдорж, Л.Төрбаяр, Л.Зоригт, С.Баярмөнх, Б.Эрдэнэбат, П.Батнайрамдал гээд олон нэртэй сэтгүүлчид төрөн гарсан байдаг юм. Сайн сэтгүүлч төрүүлэхийн төлөө махрэн зүтгэсэн хүн дээ. Өөрөө ч гайхамшигтай олон нийтлэлийг бичсэн. 1937 оны хэлмэгдүүлэлтийн тухай хамгийн анх дуугарсан хүн нь миний аав. Түүх, шашин, нийгмийн шинэчлэлийн тухай бичсэн олон даацтай нийтлэлүүд нь одоо ч надад бий. Тэр үеийн “Улаан од” хэдийгээр цэргийн сонин ч гэсэн нийгмийн салхийг сөвэлзүүлсэн, ардчиллын үүр нь байсан юм. Энгийн уншигчдад хэрэгцээтэй чухал мэдээлэл энэ л сонины хуудаснаа хэвлэгддэг байлаа шүү дээ. Өдгөө аав минь 70 гарчихсан сайхан буурал бий.

Дэслэгч Д.БОЛОРМАА



Нэвтрүүлэгт энэхүү хазара айлын тухай өгүүлдэг юм

зорьж ирсэн хазара ард түмний анхны төлөөлөгч нь тэр. Хазара түмний талаар олж авсан хамгийн анхны мэдээлэл нь үндэсний цөөнх, бас шашны цөөнх гэдэг мэдээ. Афганистаны 40 хувь нь паштун, 25 хувь нь тажик, 20 хувь нь хазара, зургаан хувь нь узбек, үлдсэн хэсэг нь олон отог омгийн үндэстэн байдаг тухай Хуссейн бидэнд танилцууллаа. Харин шашны тухайд Афганистаны 84 хувь нь исламын шашин, 15 хувь нь шиа буюу шийт урсгалыг дагадаг гэнэ.

Хазара нарын тухай аль ч эх сурвалжийн мэдээнд хазара хэмээх перс үг нь мянга гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд Чингис хааны их цэргээс энэ хавийг харгалзан үлдсэн нэг мянгатын тухай яриагаар үргэлжилнэ. Нэрт монгол судлаач Б.Я.Владимирцовын 1922 онд хэвлүүлсэн “Чингис хаан” номонд ч их хаан Туркестан, Афганистан, Персийг захирч байсан Хорезмын шах Мухамедыг 1219-1222 онд хиэр цохиод төрсөн нутаг руугаа буцахдаа эзэлсэн газартаа хэсэг цэрэг үлдээсэн тухай өгүүлдэг. Зөвлөлтийн цэрэг Афганистанд дайтаж байх үед нутгийн коммунистууд буюу Афганистаны Ардын ардчилсан намын Төв хорооноос орос генералуудад зориулан гаргасан товхимолд ч “Хазарачууд бол 13 дугаар зуунд ирж суурьшсан Монголын байлдан дагуулагчдын үр удам бөгөөд хүн амын тоогоор гуравдугаарт ордог угсаатны бүлэг болно” өгүүлсэн байдаг талаар хазара нөхөд маань ярьж байна. Ингээд олон улсын байгууллагуудад ажилладаг хазара нөхдийнхөө тусламжтайгаар Кабул хот болон хазарачууд олноороо амьдардаг Бамиян мужид ажилласан даа.

Бамияны хазарачуудын олонх нь агуйд амьдардаг тухай

гэвэл 200 километр зайтай. Зам тун муу учраас 10 гаруй цаг сэгсчүүлж явсаар Бамиянд иртэл жагсаал болж байв. Гаазын зурваст болж буй Израиль-Палестины мөргөлдөөний тухайд байр сууриа илэрхийлж, 20 хүрээгүй залуус голдуу 200 орчим иргэн уриа, лоозон болчихсон төв гудамжаараа жагсаж байх нь тэр. Хэдийгээр цагийн байдал харьцангуй сайжирч байсан ч иймэрхүү жагсаал, цуглааныг жагсагчдаасаа олон буутай цагдаа нар харгалзчихсан явдаг юм билээ. Хамгийн олзуурхуштай нь биднийг очдог 2009 онд Бамиян мужийн Засаг дарга нь эмэгтэй хүн, тэр тусмаа хазара бүсгүй байсан. Энэ улсад хамгийн хол сонсогддог “Эмэгтэй хүн”, “Хазара” гэдэг үгийг нэгтгэж, өндөрт өргөсөн бодит жишээ болохоор бас л сайхан санагдаж байсан шүү. Бид зорьсон газраа очлоо. Тэр нь Бамиян мужийн хойд уулын энгэрт хүн төрөлхтний соёлын өв болон гайхагдаж байсан Бурхан Буддагийн чулуун хөшөөний ором. Зураглалаа ч авлаа. Уг нь тэр оромд 53 болон 35 метрийн өндөртэй хоёр чулуун бурхан байсан юм билээ. Эрдэмтдийн тооцоолсноор 1500-2000 жилийн настай. Харамсалтай нь, талибууд “Хазара хүнтэй адилхан байна” гэж шалтаглан их буу, танкаар нураасан гэдэг. Биднийг очиход чулуун бурхад байсан газрыг хашаалж, хамгаалалтад авсан байсан бөгөөд их бууны суманд хэдэн хэсэг болсон үлдэгдлийг баглан боосон байв. Япончууд эргүүлэн эвлүүлэх гэж оролдож байгааг ч хазара нөхөд маань хэлэв. Мэдээж таны асуусанчлан Бамиян мужийн элгэн улаан уулын энгэрт газар нүхлэн шавар оромж хийгээд хазара нар амьдарна. Энд цахилгаан гэж юу ч байхгүй. Идэр насны эрчүүд цөөрсөн нь илт.



By Ganbayar Urtnasan



By Ganbayar Urtnasan

“Хүрээлэн” төслийн хүрээнд авагдсан зургууд

БАЙЛДААНЫ ЗЭВСЭТЛЭЛ "БҮТЛЭЭТЧИД"

Энэ удаагийн "Хобби" булангаа бид "Монголын пластик дуураймал загвар зохион бүтээгчдийн нийгэмлэг"-ээс зохион байгуулсан Байлдааны хуягт техникийн пластик загварын үзэсгэлэнгээс бэлтгэлээ. Уг үзэсгэлэнд танк, хуягт техник, нисэх онгоц, автомашин буюу бусад төрөл гэсэн гурван загвараар урлаачид бүтээлээ ирүүлсэн байна. Нийгэмлэгийн ахмад гишүүн П.Эрхэмбаярын өгсөн мэдээллээр 80 гаруй загвараар 20 гаруй тамирчин оролцсон бөгөөд тэдний тав нь сурагчид гэнэ. Пластик дуураймал загвар зохион бүтээх нь дэлхийд тэр дундаа Европын орнуудад үндэсний спорт болтлоо хөгжсөн бол манайд зөвхөн эхэлж байгаа нь энэ аж. Ердөө дөрвөн жилийн өмнөөс энэ төрлийг сонирхдог залуус нэгдэн нийгэмлэг байгуулан жилдээ 2-3 удаа цуглаж, хийж бүтээсэн бүтээлээ нэгэндээ сонирхуулдаг аж. Дуурайж хийх эх загвараа гаднын орноос захиалж авчирдаг бөгөөд энэ нь дунджаар 50 эсвэл 500 доллароос эхэлдэг гэнэ. Гэсэн ч нэгэнт энэхүү спортод шимтэн орсон залуус өөрөөсөө мөнгө харамлалгүй олон тооны эх загварыг нь захиалан авчруулдаг гэнэ.

Тэд энэ удаа цэргийн техникийг пластикаар дуурайлган урлахдаа бодит цагийн байдалд дөхүүлсэн нь сонирхогчдын анхаарлыг хамгийн ихээр татаж байлаа. Нисэх онгоц нь гэхэд мотортой мэт дуугаргагчтай, танк, хуягт техник нь цэрэгтэй, бүр дэлбэрэлтийн үеийн дүрслэлтэй байх жишээтэй. Цэргийн зэвсэглэлийн загварыг дуурайлган хийсэн авьяаслаг олон тамирчнаас хамгийн эхэнд онцлох эрхэм бол БНТУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ахмад Язал. Тэрээр "Би хүүхэд байхаасаа л эвлүүлдэг тоглоомд дуртай байлаа. Яг энэ төрөлд гэвэл 20 жилийн өмнөөс шимтэн орсон. Ажлын бус цагаараа сонирхлоо хөгжүүлэх дуртай. Одоогоор надад 70 гаруй дуураймал загвар байгаагаас 20 орчмыг нь Монгол Улсад томилогдон ирснээсээ хойш бүтээсэн. Миний нэг дутагдал нь загвар бүтээх тусмаа хугацаа нь өмнөхөөсөө илүү удааширдаг талтай. Энэ нь илүү чадваржиж, тэр хэрээр чимхлүүр ажил их хийх болсонтой холбоотой. Монгол Улсад ирснийхээ дараа над шиг сонирхолтой хүмүүс байдаг болов уу гэж цахим хуудснаас хайтал "Монголын пластик дуураймал загвар зохион бүтээгчдийн нийгэмлэг"-ийн бүлэг гарч ирсэн юм. Ингэж л энэ хүмүүстэй холбогдож, уран бүтээлийн үзэсгэлэнгээ дэлгэхэд нь тусалж, харилцан



туршлага солилцох болсон доо. Батлан хамгаалахын сайд Н.Энхболдод өөрийн урласан загвараа бэлэглэхэд тэрээр их уриалгахан хүлээж авсан. Удахгүй Монгол цэргийн музейд бэлэглэх танкны загвараа бүтээж байгаа" гэсэн юм. Элчин сайд Ахмад Язалын хувьд голдуу цэргийн зэвсэглэл, техникийн загварыг дуурайлж хийх дуртай бөгөөд үзэсгэлэнд түүний дөрвөн нисэх онгоц, 20 гаруй танк, хуягт тээврийн загвар дэлгэгдсэн байлаа.

Дараагийн урлаач залуус бол Б.Дугарсүрэн, Д.Батцэнгэл нар. Тэдний гол онцлог нь Монгол Улсын түүхийг өгүүлсэн цэргийн техник урласанд байв. Тухайлбал, Б.Дугарсүрэнгийн хувьд 2019 онд "Олон улсын цэргийн наадам"-ын хүрээнд зохион байгуулагдсан "Танкийн биатлон"-д Монгол Улсын Зэвсэгт хүчний багийнхны уралдаж оролцсон улаан өнгийн "Т-72Б3" маркийн танкийг Монгол Улсын Төрийн далбаатай хамтад нь дуурайлган бүтээжээ. "Жижигхэн болохоос биш яг л дүрээрээ байна" гээд сонирхогчид тал талаас нь сонжиж өгнө лээ. Энэ талаар Б.Дугарсүрэн хэлэхдээ "Өнгөрсөн онд монгол цэргүүд улаан танкаараа гайхамшигтай уралдсан. Үнэхээр огшоож байсан шүү. Тэр сэтгэл хөдлөл маань энэхүү улаан танкийг урлахад тусалсан" гэлээ. Тэрээр энэхүү бүтээлээ 21 хоногийн хугацаанд урласан гэнэ. Харин Д.Батцэнгэл 1941 онд ЗХУ-ын

Улаан армид монголчуудын бэлэглэсэн "Т-34" загварын танкийг мөн л яг дуурайлган урласан нь одоун байхдаа моделийг нь худалдан авсан бөгөөд саяхнаас л бодит ажил болгож, үзэсгэлэнгийн тавцанд залсан нь энэ ажээ.

Энд танк, хуягт тээвэрлэгчээс гадна байлдааны нисэх онгоцнуудын дуураймал загваруудыг ч бяцхан хүүхдүүд урласан байлаа. "Оргил" дунд сургуулийн дөрөвдүгээр ангийн сурагч Э.Тэмүгэ, 52 дугаар дунд сургуулийн 12 дугаар ангийн сурагч А.Түшиг нар АНУ, ХБНГУ, БНТУ-ын байлдааны нисэх онгоцнуудыг Төрийн далбаатай нь хамт дуурайлган бүтээсэн нь сонирхогчдын анхаарлыг ихээр татаж байсан юм. Тэдний аав Ж.Адилбиш, Б.Энхзол нар энэхүү спортоор хичээллэдэг учраас хүүхдүүдэд сайнаар нөлөөлсөн нь хийсэн бүтээлээс нь тодорхой харагдаж байв. Төгсгөлд нь онцлох бүтээгч бол нисэх загварын ууган мастеруудын нэг Ж.Адилбиш. Тэрээр энэ үзэсгэлэнд Монгол Улсад хамгийн анх буюу 1919 онд газардсан "F-13" хэмээх зорчигч тээврийн онгоцны загварыг бүтээсэн байна. Энэ л онгоц газардсанаар Монгол Улсад нисэх хүчин үүссэн гэж үздэг бөгөөд дэлхийд анх удаа металлээр хийсэн онгоц гэдгээрээ нисэхийн түүхэнд тод бичигдэн үлдсэн тухай Ж.Адилбиш ярилаа.

Дэслэгч Д.БОЛОРМАА



БНТУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ахмад Язал



Сурагч Э.Тэмүгэ онгоц бүтээх дуртай



СЭТГЭЛИЙН ЗҮЛ

Бидний эрхэмлэн хүндэтгэдэг, сайн санаат, сайхан сэтгэлт, мэддэг, чаддаг бүхнээ Зэвсэгт хүчнийхээ төлөө харамгүй зориулж явсан эрхэм хүн чөлөөнд байсан хурандаа Ж.Түмэн-Өлзий насан өөд болсон харамсалтай мэдээг сонсов.

Тэрээр эгэл даруу, энгийн, байгаагаараа л байдаг, үнэнч шударга, ажилсаг, бүтээлч үйлстэн төдийгүй хүндлэн дээдэлдэг үнэт зүйлс, хөдөлшгүй дагадаг үндсэн зарчмаа ямар ч нөхцөлд гуйвж дайвахгүй сахидаг нэгэн байлаа. Үнэнч, шударга хүн хэзээ ч нэгэн зангаараа, бурхнаас заяасан төрөлх шинжээ ямар ч үед шижир алт мэт хувиргахгүй хадгалдаг гэдэг. Тэр тийм л хүн байсан. Зөвийг нь зөвшөөрч, бурууг нь сөрөх өөрийн бодолтой хүн байснаараа хамт олныхоо итгэл, хүндэтгэлийг хүлээж, тэднээ манлайлан оройлж, бас тэднээрээ хүрээлүүлж чадсан нэгэн.

Монголын Ардын Армийг өргөтгөн зохион байгуулах ажлын оргил ачааллын үед хамгийн хүнд, олон талтай, нарийн төвөгтэй, тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байсан 1970-аад оны сүүлч, 1980-аад оны эхэнд Ар талыг удирдах газрын Хүнсний хэлтсийн даргын албыг 10 жил хашсан юм.

Ардын Армийн шинээр зохион байгуулагдсан болон бусад бүх нэгтгэл, ангийн ердийн галлагаатай цэргийн гал тогоонуудыг цахилгаанжсан гал тогоотой болгох, хүнсний бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалтыг хийх цахилгаан хэрэгслэлээр хангах, байгалийн салхин хөргүүртэй мөсөн агуулахуудыг барьж ашиглалтад оруулах, тогооч бэлтгэх дамжааг байгуулах, байлдааны болон тайван цагийн хүнсний хангалтын удирдлагын баримт бичгийг шинэчлэн боловсруулах нүсэр ажлыг тэрээр гачдан хийж, зохион байгуулсан юм. Цэргийн сангийн аж ахуйг байгуулан нэгтгэл, ангиудыг төмс, хүнсний ногоогоор хангах, мал, махны бэлтгэлийн нөөцийг бий болгох зорилгоор шаардлагатай үед нөхөн хангалт хийх Армийн мал бааз (Зэвсэгт хүчний 232 дугаар анги)-ыг байгуулах, хүнсний мэргэжлийн боловсон хүчнийг гадаад, дотоодын их, дээд сургуулиар бэлтгэх зэрэг бодлогын чанартай олон бүтээлч ажил нь хурандаа Ж.Түмэн-Өлзийгийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Тэр л үеийн ачааны хүндийг үүрэлцсэн ахмад дайчдын нэг.

Санаа зөв, сайн үйлстнүүдийн үлдээсэн цагаан мөр, гэзгэн үйлс хойч үедээ ч буян болдгийг бид мэдэрч билээ. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн шилжилтийн хүнд үед Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний үе үеийн удирдлага, ахмад дайчдын маань бүрдүүлж өгсөн урсгал болон дайчилгааны нөөцийг зохистой зарцуулж, тухайн нийгмийн шалгуурыг ямар ч эрсдэлгүй давж цэргийн Ар талын хангалтыг тасралтгүй явуулж байсан нь тэр он цагт ажиллаж байсан ахмад буурлуудын маань л буян. Тэр буянтнуудын нэг нь Ж.Түмэн-Өлзий хурандаа байлаа.

Зэвсэгт хүчнийхээ түүхэнд үлдэх мөртэй, бүтээлч үйлстэй, дуурсах алдартай өмнийн цэнхэр говийн өгөөмөр сэтгэлтэй эгэл нэгэн хүү бурхны орноо морилон одлоо. Ум сайн амгалан болтугай.

Бэлтгэл дэд хурандаа Ч.ДАШДЭЛЭГ

ЭМГЭНЭЛ

ЖАМЦЫН ТҮМЭН-ӨЛЗИЙ /1938-2019/



Зэвсэгт хүчний шилдэг дарга нарын нэг, ар талын чадварлаг, туршлагатай ажилтан, чөлөөнд байсан хурандаа Жамцын Түмэн-Өлзий хүнд өвчний учир таалал төгсөж бидэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.

Ж.Түмэн-Өлзий нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цавчир гэдэг газар 1938 онд төрсөн. 1960 онд Ардын Армийн 019 дүгээр анги дугаар цэргийн алба хааж, 1962-1966 онд ЗХУ-ын Вольск хотын Цэргийн ар талын дээд сургууль, 1971-1974 онд Цэргийн ар тал, тээврийн академид тус тус суралцаж төгсчээ. Тэр бээр 1966-1968 онд Ардын Армийн 028 дугаар ангийн хувцас, орон сууцны албаны дарга, 1968-1971 онд 019 дүгээр ангийн ар талын орлогч дарга, 1974-1976 онд МАА-ийн Ар талыг удирдах газрын штабын орлогч дарга, 1976-1986 онд Хүнсний хэлтсийн дарга, 1986-1989 онд ХААДС-ийн Цэргийн тэнхмийн даргаар ажиллаж байгаад гавьяаныхаа амралтанд гарсан юм.

Тэрээр армийн хүнсний хангалтыг удирдан зохион байгуулах, хугацаат цэргийн алба хаагчдын ая тухтай хооллох орчин, нөхцөлийг

БХЯ, ЗХЖШ, АР ТАЛЫН ГАЗАР, ЗХЖШ-ЫН АХМАДЫН ХОРОО, "МОНГОЛ ХУРАНДАА" НИЙГЭМЛЭГ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ "АР ТАЛЫН АЖИЛТНЫ ХОЛБОО" ТББ, ТАЛИЙГААЧИЙН ГЭР БҮЛ, ҮР ХҮҮХДҮҮД, АХАН ДҮҮС, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД, АНД НӨХӨД НЬ

ЖИГМЭДИЙН БААТАРЗОРИГ /1966-2019/



Бидний журмын нөхөр, жудагтай удирдагч, халамжит хань, хайртай аав, бэлтгэл хурандаа Жигмэдийн Баатарзorig нь хүнд өвчний улмаас таалал төгсөж, бидэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.

Ж.Баатарзorig нь 1966 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Ховд аймгийн Жаргалант суманд төрсөн. 1984 онд Ховд аймгийн 10 жилийн хоёрдугаар дунд сургууль, 1988 онд ЦНДС-ийг ар тал, эдийн засагч мэргэжлээр, 1999 онд БХУА-ийг оператив, тактик-команд штабын мэргэжлээр тус тус төгссөн.

Тэрээр 1988-1990 онд Ардын Армийн 072 дугаар ангийн албаны дарга, 1990-1997 онд Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн албаны дарга, 1997-1999 онд БХУА-ийн сонсгогч, 1999-2004 онд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн захирагчийн

бүрдүүлэх хангалтыг тасралтгүй, шуурхай зохион байгуулах ажилд өөрийн бие сэтгэл, мэдлэг, боловсролоо зориулж явсан ар талын тэргүүний ахмад ажилтнуудын нэг байлаа. Армийн бие бүрэлдэхүүний хүнсний хангамжийг сайжруулах, илчлэг сайтай хоол, хүнсээр хангах, хээрийн нөхцөлд хийх удаан хадгалалт даах, халуун боловсруулалт шаардахгүй шууд хэрэглэх боломжтой хүнсийг буй болгох зорилгоор хүнсний нормыг шинэчлэн "Хээрийн хуурай хүнсний иж бүрдэл"-ийг шинээр хийж, туршилтын журмаар хэрэгжүүлсэн юм. Энэ хүрээнд цэргийн зориулалттай хатаасан талх, малын цусан хатаамал, гахайн өөхийг давсалж боловсруулан консервлох, төрөл бүрийн хүнсний ногоо даршлах аргуудын технологийг ХХУЯ, МУИС-ийн холбогдох лаборатори, кабинетуудтай хамтран боловсруулж "Шинэ бүтээл, оновчтой санал"-ын батламжийг авч, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн юм.

Ж.Түмэн-Өлзийгийн идэвх зүтгэл, үр бүтээлтэй олон жил ажилласан ажлын амжилт, хөдөлмөрийг үнэлж, Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны одон, Цэргийн хүндэт медаль, Улс, хувьсгалын болон Зэвсэгт хүчний ойн медалиуд, БХЯ-ны Хүндэт тэмдгээр шагнасан юм.

Түүний ажилч хичээнгүй, хөдөлмөрч, шударга зан чанар нь бидний зүрх сэтгэлд үүрд хоногшин үлдэх болно.

БХЯ, ЗХЖШ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 120, 123, 186, 310, 325, 339 ДҮГЭЭР АНГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН УДИРДЛАГЫН АКАДЕМИ, ЦНДС-ИЙГ ХАМТ ТӨГСӨГЧИД, ТАЛИЙГААЧИЙН АХ, ЭГЧ, ДҮҮ, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД, ҮР ХҮҮХДҮҮД НЬ



Г.ЭРДЭНЭЧУЛУУН /1963-2019/

Чөлөөнд байсан хошууч Г.Эрдэнэчулуун нь 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зуурдаар таалал төгсөж, хань, ах дүү, найз нөхөд, төрөл төрөгсөд нь нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо. Г.Эрдэнэчулуун нь 1963 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, 1971-1981 онд Нийслэлийн ерөнхий боловсролын 24 дүгээр дунд сургууль, 1981-1985 онд Цэргийн нэгдсэн дээд сургуулийг хуягт автомашины инженер мэргэжлээр тус тус төгссөн. 1985-1996 онд Зэвсэгт хүчний 167 дугаар анги дотроо

салбарын захирагч, мотобуудлагын батальоны штабын дарга, 1996-1997 онд Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн соёл хүмүүжил эрхэлсэн орлогч, 1997-2000 онд БХИС-ийн Ахлагч бэлтгэх сургуулийн курсийн дарга, 2000-2006 онд Зэвсэгт хүчний 016 дугаар бригадын соёл хүмүүжил эрхэлсэн орлогч, хуягт танкийн хадгалах тасгийн инженер зэрэг албан тушаалыг хашиж байлаа.

Түүний хөдөлмөр, зүтгэлийг нь өндрөөр үнэлж, "Дайчин алдар II, III" хүндэт медаль болон бусад ойн медалиар шагнаж урамшуулсан юм.

Г.Эрдэнэчулуун эгэл даруу, хүнлэг, нөхөрсөг, бүтээлч хөдөлмөрч зан чанар, элэгсэг дотно дүр төрх нь бидний зүрх сэтгэлд үүрд хоногшин үлдэх болно.

ХАНЬ, АХ ДҮҮ, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД, АНД НӨХӨД, КУРСИЙН ХАМТ ОЛОН НЬ

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 95 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч Хурандаа Батжаргалын ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонини редакцияд бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламгыг хямд нийтэлнэ.
*Зар, рекламны үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болол сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029